



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ



Улаанбаатар хот
2024 он



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Улаанбаатар хот
2024 он

ННА 65
ДАА 330
Б-341

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Судалгаа хийсэн:

С.Баттулга ахлагчтай “Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв” ТББ-ын баг

Энэхүү судалгааны үр дүн, санал зөвлөмж нь уг судалгааг гүйцэтгэсэн багийн үзэл бодол, байр суурь бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг төлөөлөхгүй.

Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

ISBN 978-9919-9136-0-1

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1
Утас: 976-76113207
Веб: <http://www.forum.mn>
Мэйл: osf@forum.mn

АГУУЛГА

Товчилсон үгс	6
Өмнөх үг	7
Хураангуй	8
1. Удиртгал	10
2. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал.....	12
3. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлага	15
4. Монгол Улсын 2017, 2019, 2021, 2022 оны төсвийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалтын төслүүд төсөвлөлтийн зохих шаардлагыг хангасан уу?	18
2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд	18
2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд	24
2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд	26
2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд	28
5. Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт	33
6. Кейс судалгаа: Хэрэгжилт нь удааширсан төсөл, арга хэмжээнүүд	39
Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилга	40
Үндэсний номын сангийн барилга	42
“Төв халх” дуулалт жүжгийн театрын барилга	44
Завхан аймгийн хөгжимт жүжгийн театрын барилга	45
7. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын олон улсын туршлага	48
8. Дүгнэлт, зөвлөмж	50
Ном зүй	52
Хавсралтууд	54

Зургийн жагсаалт

Зураг 1.	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тоо, 2017-2023 он	12
Зураг 2.	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөг, санхүүжих дүн ба тэдгээрийн харьцаа, 2017-2023 он.....	13
Зураг 3.	2022 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, үргэлжилж буй жилээр.....	29
Зураг 4.	2022 оны төсвийн хөрөнгө оруулалт: Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулаагүй батлагдсан төсөл, арга хэмжээний тоо, салбараар.....	30
Зураг 5.	2022 оны төсвийн хөрөнгө оруулалт: Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулаагүй батлагдсан төсөл, арга хэмжээ, байршлаар	30
Зураг 6.	Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслийн тоо, эх үүсвэрийн төрлөөр	33
Зураг 7.	Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөвт өртөг, эх үүсвэрийн төрлөөр, их наяд төгрөг	34
Зураг 8.	“Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга” төслийн явцын зураглал.....	41
Зураг 9.	Үндэсний номын сангийн барилгын төслийн явцын зураглал.....	44
Зураг 10.	Завхан аймгийн хөгжимт жүжгийн театрын төслийн явцын зураглал.....	46

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тоо, 2017-2023 он	12
Хүснэгт 2.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагууд.....	16
Хүснэгт 3.	2017 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт анх туссан оноор	18
Хүснэгт 4.	2017 оны төсвийн хөрөнгө оруулалт: Зураг, төсөв нь алдаатай хийгдсэн төсөл, арга хэмжээ	20
Хүснэгт 5.	2017 оны төсвийн хөрөнгө оруулалт: Холбогдох үнэлгээ, судалгааг дутуу хийлгэсэн төсөл, арга хэмжээ	21
Хүснэгт 6.	Бусад төрлийн зөрчилтэй төсөл, арга хэмжээ	23
Хүснэгт 7.	2019 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт анх туссан оноор	24
Хүснэгт 8.	2021 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт анх туссан оноор	26
Хүснэгт 9.	2021 оны төсвийн хөрөнгө оруулалт: Шинээр батлагдсан төсөл арга хэмжээний зураг, төсөв боловсруулсан байдал.....	27
Хүснэгт 10.	2022 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт анх туссан оноор	28
Хүснэгт 11.	2022 оны төсвийн хөрөнгө оруулалт: Шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулсан байдал	29
Хүснэгт 12.	Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголд тусгагдсан улсын төсвийн эх үүсвэртэй төслүүд	35
Хүснэгт 13.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан улсын төсвийн санхүүжилттэй төсөл, арга хэмжээний тоо.....	37
Хүснэгт 14.	Хэрэгжилт нь ноцтой удааширсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжууд.....	39
Хүснэгт 15.	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 960 хүүхдийн суудалтай сургуулийн төсөвт өртгийн өөрчлөлт, 2012-2023 он	40
Хүснэгт 16.	“Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга” төслийн Монголын талын хөрөнгө, 2018-2023 он	41
Хүснэгт 17.	Үндэсний номын сангийн барилгын төсөвт өртгийн өөрчлөлт, 2012-2023 он	42
Хүснэгт 18.	“Төв халх” дуулалт жүжгийн театрын төсөвт өртгийн өөрчлөлт, 2011-2023 он	44
Хүснэгт 19.	Завхан аймгийн хөгжимт жүжгийн театрын төсөвт өртгийн өөрчлөлт, 2011-2023 он	45

Товчилсон үгс

АХБ	Азийн хөгжлийн банк
БЗД	Баянзүрх дүүрэг
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ЕХ	Европын холбоо
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
МУСОНБТСҮХ	Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороо
МЭЗШСТ	Монголын Эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
ОУВС	Олон улсын валютын сан
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТТХ	Төсвийн тухай хууль
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТЭЗУС	Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

Өмнөх үг

Улсын төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах нь улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй. Иймд Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт болон хэрэгжилтийг С.Баттулга ахлагчтай “Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв” ТББ-ын баг судалж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр зөвлөмж гаргасныг сонирхогч талуудад хүргэж байна.

2017-2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг авч үзэхэд төсөл анх төлөвлөсөн хугацаандаа дуусахгүйгээр олон жил дамжин шилжих тохиолдол их байна. Хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт ийнхүү удаашрахад тухайн төслийг гүйцэтгэгч өөрөөс хамааран хугацаандаа ажлаа дуусгаагүй, санхүүжилт хугацаандаа олгогдоогүй зэрэг шалтгаан түгээмэл нөлөөлсөн хэдий ч анхнаасаа төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг буруу хийсэн, зураг төсөл, газрын зөвшөөрөл нь шийдэгдээгүй төслийг улсын хөрөнгө оруулалтын төсөвт тусган баталсан зэрэг нь тухайн төсөл хугацаандаа хэрэгжихгүй, он дамжин шилжихэд хүргэж байна хэмээн судалгааны баг дүгнэжээ.

Хөрөнгө оруулалтын төслүүд олон жил үргэлжилснээр төсөвт өртөг нь нэмэгдэж, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах үндсэн шалтгаан болж байгааг судлаачдын зүгээс онцлоод тодорхой зөвлөмжүүдийг санал болгожээ. Үүнд, Төсвийн тухай хууль болон “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг хэлбэрэлтгүй мөрдүүлэх; өмнөх оноос шилжин хэрэгжиж буй төслүүдэд шаардагдах санхүүжилтийг жилийн Төсвийн тухай хуульд нэн тэргүүнд тусгах; гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ажлаа цаг хугацаандаа дуусгаагүй гүйцэтгэгчийн жагсаалтыг олон нийтэд ил тод мэдээлэх, тухайн гүйцэтгэгчээр дахин ажил гүйцэтгүүлэхгүй байх, үлдсэн ажлыг өөрийнх нь хөрөнгөөр дуусгуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуульд тусгах зэрэг болно.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийн шатны хяналт, хариуцлагыг дээшлүүлэх асуудлаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд энэхүү судалгаа чухал хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

Судалгааг хийж гүйцэтгэсэн С.Баттулга ахлагчтай судалгааны баг, судалгааны тайланг сайжруулахад үнэтэй санал, шүүмж өгч ажилласан хөндлөнгийн шинжээч Д.Амаржаргал, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам нарт талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

Хураангуй

Энэхүү судалгааны ажлаар 2017, 2019, 2021 болон 2022 онд батлагдсан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль болон “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан шаардлагыг хангаж буй эсэхийг судлахыг зорилгоо. Мөн Монгол Улсын 2018-2021, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын төсвийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээнүүдийн хувьд авч үзэв. Түүнчлэн 2023 оны байдлаар 10-аас дээш жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээнүүдээс сонгон авч, ямар шалтгааны улмаас удааширсан, ямар асуудлууд тулгамдсан, хэрхэн шийдвэрлэхээр ажиллаж байгаа зэргийг судаллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг, санхүүжилтийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа ч хэрэгжилт нь удааширч, он дамжин шилжих тохиолдол их байна. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт хугацаандаа дуусаагүйд тухайн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч хугацаандаа ажлаа дуусгаагүй, санхүүжилт хугацаандаа олгогдоогүй зэрэг шалтгаан түгээмэл байсан хэдий ч анхнаасаа төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг буруу хийсэн, зураг төсөл, газрын зөвшөөрөл нь шийдэгдээгүй төсөл, арга хэмжээг улсын хөрөнгө оруулалтын төсөвт тусган баталсан зэрэг нь тухайн арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй он дамжин шилжих бас нэгэн шалтгаан болсоор байна. Өөрөөр хэлбэл Төсвийн тухай хууль болон “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын холбогдох заалтуудыг зөрчиж, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулан баталсаар байна гэсэн үг юм.

Түүнчлэн хугацаандаа хэрэгжилгүй он дамжиж буй төсөл, арга хэмжээг шилжүүлэхдээ анх батлагдсан хугацааг өөрчлөн, шинэ төсөл, арга хэмжээ мэтээр тусгах зэрэг зөрчлүүд ч улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдэд цөөнгүй байгаа нь 2017, 2019, 2021, 2022 оны төсвөөс ажиглагдлаа. Төсөл, арга хэмжээний батлагдсан жагсаалт, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем зэрэг нийтэд ил тод байдаг мэдээллийн эх сурвалжаас шалгахад төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэхдээ буюу тендерийг зарлахдаа тухайн төслийн зураг төслийг боловсруулах ажлын даалгаврыг хавсаргаж буй тохиолдлууд түгээмэл байсан бөгөөд зураг төсөл нь бэлэн болоогүй, шаардлагатай судалгаа, төлөвлөлт нь хийгдээгүй батлагдсан эдгээр төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй, он дамжин шилжих нь ойлгомжтой юм. Мөн хэрэгжүүлэх арга хэмжээ, төсвийн зарцуулалт тодорхой бус олон тооны арга хэмжээг багцлан нэг ерөнхий утгаар тусгасан, төслийн хүчин чадал, байршлыг заагаагүй зэрэг зөрчилтэй төсөл, арга хэмжээ улсын төсөвт тусгагдсаар байгаа бөгөөд эдгээр зөрчлөөс шалтгаалан тухайн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанарыг хэрхэн үнэлэх, төсвийн зарцуулалтад хэрхэн хяналт тавих зэрэг нь тодорхой бус байна.

Төсөвт өртөг өндөртэй төсөл, арга хэмжээнүүдийн тухайн төсвийн жилд санхүүжих дүнг зохих шаардлагыг хангасан байдлаар батлахгүй байгаагаас хэрэгжилт нь удааширах, улмаар шилжих төсөл, арга хэмжээний тоо нэмэгдэх үндсэн шалтгаануудын нэг болж байгаа юм. Түүнчлэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зарим төсвийн

жилүүдэд орхигдуулснаар төсөл, арга хэмжээний гүйцэтгэл саатаж, эхний шатны хөрөнгө оруулалтын үнэ цэн алдагдаж, дахиж эхлэхээс өөр аргагүй болж байсан тохиолдлууд ч байна. Энэ нь нөгөөтээгүүр төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэж, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулж байгаагийн үндсэн шалтгаан болдог. Тиймээс төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зохих ёсоор төсөвлөж, хуульд заасан хугацаанд хэрэгжүүлж дуусгах хэрэгтэй байна.

Олон тооны төсөл, арга хэмжээ хугацаандаа дуусалгүй, олон жил дамнан үргэлжилсээр байхад тэдгээр төсөл, арга хэмжээг дуусгахын тулд санхүүжилтийг нь гүйцээж батлахад анхаарахын оронд шилжих төсөл, арга хэмжээний тооноос дутуугүй, зарим тохиолдолд давж гарсан тооны шинэ төсөл, арга хэмжээ, барилга байгууламж улсын төсвийн хөрөнгөөр барьж, байгуулахаар баталж байгаа нь хөрөнгө оруулалтын төсөвлөлт төлөвлөлтийн шатнаасаа эхлэн зохисгүй байгааг илтгэж байгаа юм.

Судалгааны үр дүнд суурилсан дээрх дүгнэлтүүдэд үндэслэн дараах зөвлөмжийг судлаачдын зүгээс хууль тогтоогч нар болон Засгийн газарт хүргүүлж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль болон “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хэлбэрэлтгүй мөрдүүлэх;
- Эх үүсвэр үл хамааран улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээг жилийн төсвийн төсөлд тусгахгүй байх;
- Хэрэв гурваас илүү жил шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ, барилга байгууламж ирэх жилийн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөж буй жагсаалтын 50-иас илүү хувийг эзлэхээр байвал батлагдах жагсаалтад шинэ төсөл, арга хэмжээ, барилга байгууламж тусгадаггүй байх зохицуулалтыг Төсвийн тухай хуульд тусгах;
- Хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд гэрээгээр биелүүлсэн үүргээ гүйцэтгээгүй, ажлаа цаг хугацаандаа дуусгаж чадаагүй гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулах, хар жагсаалтыг олон нийтэд ил тод мэдээлэх, тухайн гүйцэтгэгчээр дахин ажил гүйцэтгүүлэхгүй байх, үлдсэн ажлыг өөрийнх нь хөрөнгөөр дуусгуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуульд тусгах;
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлтөөс эхлээд гүйцэтгэж дуусах хүртэл бүхий л үе шатыг хамарсан цахим хувийн хэрэг нээж, олон нийтэд ил тод болгох замаар олон нийтийн хяналтад оруулах;
- Холбогдох хууль, журмыг зөрчсөн албан тушаалтанд зохих арга хэмжээг заавал авах, хүлээх хариуцлагыг чангаруулах.

1. Удиртгал

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах ба энэхүү баримт бичигт хөрөнгө оруулалтын хөтөлбөр мөн багтсан байхаар заасан.¹ Эдгээр баримт бичигт тусгагдсан зорилтуудад нийцүүлсэн төсөл, арга хэмжээг тодорхойлж, шаардагдах санхүүжилтийг нь жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлэх зохицуулалттай. Жил бүрийн Төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт батлагддаг. Төсвийн тухай хууль болон бусад холбогдох журамд заасан зохих шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээ л энэхүү жагсаалтад багтаж, улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах учиртай юм.

Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуулиудыг үзэхэд 2010 оноос хойш үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээ байсаар байна. Эндээс төсөл, арга хэмжээ яагаад ийм олон жил үргэлжилж байна вэ, ямар асуудлууд тулгамдаж байгаа, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх вэ гэх зэрэг олон асуулт урган гарах бөгөөд эдгээр асуудлыг судалж, улсын төсвийн хөрөнгө оруулалтыг илүү үр дүнтэй, хэрэгжилт сайтай болгоход чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахыг энэхүү судалгааны хүрээнд зорилоо.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн төсөлд тусгах төсөл, арга хэмжээг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ; их засвар арчлалтын төсөл, арга хэмжээ; шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ гэсэн эрэмбийг баримтална гэж тусгасан байдаг. Гэтэл улсын төсвийн хөрөнгө оруулалттай зарим төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа дуусалгүй он дамжин шилжиж буй нь шинэ төсөл, арга хэмжээг улсын төсөвт суулган хэрэгжүүлэх боломжийг алдагдуулж байгаагаас гадна шилжих явцдаа төсөвт өртөг нь нэмэгдэж, улмаар дуусалгүй орхигдож байгаагаас улсын төсвийн хөрөнгө оруулалт үр дүнгүй, үр ашиг муутай зарцуулагдахад хүрч байгаа юм.

Төсвийн хөрөнгө оруулалттай эдгээр төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаа нь гүйцэтгэгч байгууллагууд төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд дуусгаж чадаагүйгээс шалтгаалах тохиолдол олон байгаа ч анхнаасаа төсвийн ерөнхийлөн захирагчид төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй буюу зураг төсөв нь баталгаажаагүй, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл авагдаагүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй,

1 Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” батлагдсан ч тун удалгүй Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотгол”-ыг баталжээ. Харин Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт болон батлагдсан. Өмнөх хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс ялгаатай нь тус хөтөлбөрийг анх удаа 5 жилийн хугацаатайгаар УИХ-аас баталсан юм.

бэлтгэл хангагдаагүй төсөл, арга хэмжээг оруулснаас төсөл, арга хэмжээний худалдан авалт цаг хугацаандаа явагдахгүй байх, төсөл, арга хэмжээний судалгаа, тооцоолол буруу хийгдсэнээс дуусгах боломжгүй хугацаа төлөвлөх, хүрэлцэхгүй төсвийг хуваарилуулах зэргээс мөн шалтгаалж байна.

Судалгааны ажлын хоёрдугаар бүлэгт Монгол Улсын 2017-2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөг, санхүүжих дүн, тэдгээрийн өөрчлөлтийг авч үзлээ. Гуравдугаар бүлэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлагын талаар хэлэлцсэн бол дөрөвдүгээр бүлэгт 2017, 2019, 2021 болон 2022 онд батлагдсан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль болон “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан шаардлагыг хангаж буй эсэхийг судалсан үр дүнг орууллаа. Дараагийн бүлэгт Монгол Улсын 2018-2021, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын төсвийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээнүүдийг хувьд авч үзэв. Зургаадугаар бүлэгт 2023 оны байдлаар 10 ба түүнээс дээш жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээнүүдээс сонгон авч ямар шалтгааны улмаас удааширсан, ямар асуудлууд тулгамдсан, хэрхэн шийдвэрлэхээр ажиллаж байгаа зэргийг авч үзсэн кейс судалгаа орсон. Төлөвлөсөн хугацаандаа дуусдаггүй, төсвийн хөрөнгийг үрэлгэн, үр дүн муутай зарцуулдаг төсөл, арга хэмжээг төлөвлөж, төсөвлөхгүйн тулд цаашид юу хийх хэрэгтэй байгаа талаар олон улсын туршлагад суурилан долоодугаар бүлэгт хөндөж, тайлангийн сүүлийн бүлэгт судалгааны дүгнэлт, зөвлөмжийг орууллаа.

Тус судалгааны ажлыг гүйцэтгэх боломж олгосон Нээлттэй Нийгэм Форумын хамт олон, тэр дундаа үнэтэй санал, зөвлөмж өгч, хамтран ажилласан ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам болон хөндлөнгийн шүүмжлэгчид судалгааны багийн зүгээс талархал илэрхийлье.

Монголын Эдийн засгийн шинжилгээ, судалгааны төвийн судлаачид

2. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал

Монгол Улсын 2017-2023 оны төсвийн тухай хуульд давхардсан тоогоор 7,360 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.


Хүснэгт 1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тоо, 2017-2023 он

Он	Барилга байгууламж		Их засвар		Тоног төхөөрөмж		ТЭЗҮ, зураг төсөв		Нийт
	Шилжих	Шинэ	Шилжих	Шинэ	Шилжих	Шинэ	Шилжих	Шинэ	
2017	321	12	6	5	6	13	10	0	373
2018	112	456	1	106	1	68	0	5	749
2019	341	659	27	165	4	72	1	12	1,281
2020	473	444	24	250	6	140	0	10	1,347
2021	527	260	81	88	28	90	4	23	1,101
2022	615	447	53	55	30	140	7	22	1,369
2023	977	3	69	2	67	4	17	1	1,140
Нийт	3,366	2,281	261	671	142	527	39	73	7,360

Эх сурвалж: Монгол Улсын 2017-2023 оны төсвийн тухай хууль

Дээрх тоон мэдээллээс үзэхэд 2019 оноос эхлэн 1,000 гаруй төсөл, арга хэмжээг тухайн төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөдөг болсон. Түүнчлэн ихэнх төсөл, арга хэмжээ нь барилга байгууламж байдаг бөгөөд нийт төсөл, арга хэмжээний 70 гаруй хувийг эзэлжээ. Их засвар, тоног төхөөрөмжийн хувьд ихэнх жилд шинэ төсөл, арга хэмжээний тоо шилжих төсөл, арга хэмжээний тооноос илүү байсан бол барилга байгууламжийн хувьд 2017, 2023 он зүй ёсоор анхаарал татаж байна. 2017 онд манай улс Олон улсын валютын сан (ОУВС)-гийн хөтөлбөрт хамрагдаж байсантай холбоотойгоор төсвийн сахилга бат эрс сайжирсан тул шинээр олон тооны төсөл, арга хэмжээ төлөвлөөгүй бол 2023 оны төсвийн жилд шилжих төсөл, арга хэмжээнүүдийг дуусгах, шинэ төсөл, арга хэмжээний тоог хязгаарлах чиглэлийг Засгийн газраас баримталсан учир маш цөөн тооны шинэ төсөл, арга хэмжээ төлөвлөгджээ.

Зураг 1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тоо, 2017-2023 он




Эх сурвалж: 2017-2023 оны төсвийн тухай хуулиуд

Жилээс жилд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн тоо нэмэгдэж байна (Зураг 1). Тухайлбал, 2017 онд 373 төсөл хэрэгжихээр батлагдаж байсан бол 2023 онд 1140 болж өсжээ.

Хөрөнгө оруулалтын төслийн төрлийн хувьд бүх хугацаанд барилга байгууламж, тэр дундаа шилжих барилга байгууламж зонхилох хувийг эзэлж байна. 2017, 2023 оныг эс тооцвол бусад онуудад шилжих барилга, байгууламжийн тооноос дутахааргүй олон тооны шинэ барилга, байгууламж төлөвлөгджээ. Өөрөөр хэлбэл **улсын төсвийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдээс барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээнүүд олон он дамжиж шилжих нь түгээмэл байгаа тул гүйцэтгэлд нь онцгойлон анхаарах хэрэгтэй** байна.

Хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртөг болон санхүүжих дүн жилээс жилд нэмэгдэж байна (Зураг 2). Тухайлбал, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 2.69 их наяд төгрөгийг төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид зарцуулахаар хөрөнгө оруулалтын төсөв батлагдсан байна. Энэ нь өмнөх 2022 он (1.39 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт)-той харьцуулахад 1.9 дахин, 2018 он (683.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт)-той харьцуулахад 3.9 дахин өссөн үзүүлэлт юм. Гэвч тухайн төсвийн жилд санхүүжих дүн төслийн төсөвт өртгийн харьцангуй бага хувьтай тэнцсээр ирсэн нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид хангалттай санхүүжилт батлахгүй байгааг илтгэж байгаа юм. Тодруулбал, 2017-2023 оны төсвийн жилүүдэд нийт төсөвт өртгийн дөнгөж 33.2 хувьтай тэнцүү санхүүжилт батлагджээ. Уг хувь хамгийн өндөр байсан жил буюу 2019 онд төсөвт өртгийн 50 хувьтай тэнцэх санхүүжилт батлагдсан байна.

Зураг 2. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөг, санхүүжих дүн ба тэдгээрийн харьцаа, 2017-2023 он



Эх сурвалж: Монгол Улсын 2017-2023 оны төсвийн тухай хуулиуд

Ийнхүү харьцангуй бага хэмжээний санхүүжилт батлагдах нь улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэл удаашрах нэг үндсэн шалтгаан болж байгаа юм. Жишээлбэл, 2011 оны төсвийн тухай хуульд ХҮИ.2.1.12 хуулийн дугаартайгаар 2011-2013 онд хэрэгжихээр батлагдсан Дундговь аймагт байршилтай “Төв халхын дуулалт жүжгийн театр” төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 6.8 тэрбум төгрөг байхад 2011 онд ердөө 440 сая төгрөг буюу төсөвт өртгийн дөнгөж 6.5 хувийг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байгаа юм. Тэгсэн хэр нь хоёрхон жилийн дараа буюу 2013 онд дуусгана гэж төлөвлөсөн нь бодитой биш байсныг өнөөдөр хүртэл дуусаагүй театрын барилга гэрчилж байна. Тэр бүү хэл Төсвийн тухай хуулийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” гэсэн заалт байсаар байтал 2024 оны төсвийн тухай хуульд ХИ.1.1.15 хуулийн дугаартайгаар 2024-2026 онд хэрэгжихээр батлагдсан “Хүний хөгжлийн ордны барилга (Завхан, Тосонцэнгэл сум)” төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 4.5 тэрбум төгрөг байхад 600 сая төгрөгийн буюу 13.3 хувийн санхүүжилт төсөвлөгдсөн байх жишээтэй. Хуулийн дагуу бол 33.3 хувиас багагүй буюу 1.5 тэрбум орчим төгрөгийн санхүүжилт батлагдах ёстой.

3. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлага

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн талаар бүлэг заалтуудыг, мөн хуулийн 29¹ дүгээр зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг тус тус тусгасан байдаг. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлсон.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасанчлан Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг жилийн төсвийн төсөлд тусгахдаа:

- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах;
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах;
- Нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;
- Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;
- Шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;
- Тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх зэргийг хуульчилсан.

Мөн тус хуулийн 29.4-т хөрөнгө оруулалтын төсөвт **техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон** төсөл, арга хэмжээг тусгана гэсэн шаардлагыг тусгасан байдаг.

Төсвийн тухай хуулийн 29¹.1-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна” гэж заасан. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын төсөл нь энэ хуульд заасан шалгуурыг хангасан байхаас гадна холбогдох аргачлалд заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу эрэмбэлэгдсэн байна гэсэн үг юм. Төсвийн тухай хууль болон “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заагдсан шаардлагыг дараах хүснэгтээр нэгтгэн харууллаа.

Хүснэгт 2. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагууд

Төсвийн тухай хууль	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам
29 ¹ .2.1.тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;	3.2.2.1. эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;
29 ¹ .2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;	3.2.2.2. барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;
29 ¹ .2.3.техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх;	3.2.2.3. шаардлагатай тохиолдолд төслийн техник, эдийн засгийн үндэслэл, техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг хийлгэсэн байх;
29 ¹ .2.4.урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;	3.2.3.1. шаардлагатай тохиолдолд урсгал зардлыг тооцсон байх (их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөлд хамаарна);
29 ¹ .2.5.тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх;	3.2.3.2. төсвийн хязгаарт багтсан, нэн тэргүүний ач холбогдолтой байх (их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөлд хамаарна);
29 ¹ .2.6.олон нийтээр хэлэлцүүлсэн байх; ²	3.2.3.3. холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх (их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөлд хамаарна);
	3.2.3.4. тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх (их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөлд хамаарна);
	3.2.4. ТЭЗУС, ТЭЗҮ боловсруулах төсөл болон зөвлөх үйлчилгээний ажил нь холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн, тухайн байгууллага, эсхүл салбарын зорилт болон дунд хугацааны төлөвлөлтөд нийцсэн, байгууллагын эрэлт хэрэгцээ, бодит шаардлагад тулгуурласан байна.

Эх сурвалж. Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралт

2 Энэ заалтыг Төсвийн тухай хуульд 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн өөрчлөлтөөр нэмсэн.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журамд зааснаар төсвийн төсөлд тусгах төсөл, арга хэмжээг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтлах талаар тусгасан байдаг. Үүнд:

- шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ;
- их засвар, арчлалтын төсөл, арга хэмжээ;
- шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ.

4. Монгол Улсын 2017, 2019, 2021, 2022 оны төсвийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалтын төслүүд төсөвлөлтийн зохих шаардлагыг хангасан уу?

Энэхүү судалгааны хүрээнд 2017, 2019, 2021, 2022 оны улсын төсөвт батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжууд 3 дугаар бүлэгт тоймлосон холбогдох хууль, журмын шаардлагыг хангасан эсэхийг нэг бүрчлэн шалгасан. Ингэхдээ олон нийтэд нээлттэй мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглалаа. Үүнд он тус бүрийн төсвийн тухай хууль, Үндэсний аудитын газраас хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийгдсэн жил бүрийн гүйцэтгэлийн аудитын тайлан, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем, нээлттэй мэдээллийн сан (opendatalab), холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдын цахим хуудсанд тавигдсан мэдээлэл, зарим яамдын албан хаагчидтай хийсэн ярилцлага, мэдээллийн цахим хуудаснуудад³ тавигдсан мэдээллүүд зэрэг багтана. Уг судалгааны дүнг дор толилуулж байна.

2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд нийт 373 төсөл, арга хэмжээнд 631.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталснаас 342 нь буюу 92 хувь нь өмнөх онуудаас шилжсэн төсөл, арга хэмжээ байжээ. Эдгээр шилжсэн төсөл, арга хэмжээнд батлагдсан нийт төсвийн 69 хувь буюу нийт 433.8 тэрбум төгрөгийн төсөв хуваарилагдсан.

Хөрөнгө оруулалтын шилжсэн төслүүд дунд төсөвт өртөг нь өөрчлөгдөж туссан төсөл 201 байгаа нь нийт шилжсэн төслийн 59 хувьтай тэнцэж байна. Улсын төсөвт тусгагдсан эдгээр төсөл нь 2006 оноос эхлэн төсөвт суун, хугацаандаа дуусалгүй 2017 оны төсвийн жил хүртэл шилжжээ.

Хүснэгт 3. 2017 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт анх туссан оноор

№	Төсөвт анх туссан он	Шилжсэн төслийн тоо	Нийт шилжсэн төсөлд эзлэх хувь
1	2006-2009 онд анхлан туссан төсөл	8	2.3
2	2010 оноос хойш шилжиж буй	13	3.8
3	2011 оноос хойш шилжиж буй	22	6.4
4	2012 оноос хойш шилжиж буй	68	19.9
5	2013 оноос хойш шилжиж буй	66	19.3
6	2014 оноос хойш шилжиж буй	101	29.5
7	2015 оноос хойш шилжиж буй	28	8.2
8	2016 оноос хойш шилжиж буй	36	10.5

Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль

3 news.mn, gogo.mn, ikon.mn, montsame.mn зэрэг мэдээллийн томоохон агентлагуудын цахим хуудасны мэдээллийг албаны эх сурвалжийн мэдээллээр давхар баталгаажуулж ашигласан.

Шилжсэн төслүүд: Эдгээр шилжсэн төслийн дунд шилжихдээ улсын төсөвт анх тусгагдсан оныг өөрчлөн шилжүүлсэн тохиолдлууд мөн байна. Тухайлбал, анх 2012 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд XIII.1.1.43 хуулийн дугаартай батлагдаж, 2012-2014 онд хэрэгжихээр байсан “Увс аймгийн төвийн авто замын барилгын ажил (Увс, Улаангом сум)” төсөл, арга хэмжээ 2017 оны төсвийн тухай хуульд хэрэгжих хугацаа нь 2014-2017 он болж өөрчлөгдсөн байх жишээтэй. Нийт 17 төсөл, арга хэмжээ он дамжин шилжихдээ анх батлагдсан он өөрчлөгдөн шилжжээ (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү). Зарим жишээ дурдвал, Халзанбүргэдэй-Солонготын даваа чиглэлийн 100 км авто замын ажил анх 2012 онд эхэлж, 2014 онд дуусахаар төлөвлөгдсөн байсан боловч 2017 оны төсөвт шилжин батлагдахдаа 2014 онд эхэлж, 2017 онд дуусах төсөл, арга хэмжээ мэтээр тусгагдсан байсан бол Говь-Алтай аймгийн Бугат сумын сургуулийн барилгын өргөтгөл 2012 оны төсвийн тухай хуульд анхлан тусгагдахдаа 2016 онд дуусгахаар төлөвлөгдсөн ч хожим 2017 онд шилжин батлагдахдаа 2015-2017 онд хэрэгжих төсөл, арга хэмжээ мэтээр төлөвлөгдсөн байна.

Он дамжин шилжиж буй төсөл, арга хэмжээнүүд нь зарим онуудад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад багтаагүй тохиолдлууд мөн байна. Жишээ дурдвал, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км авто замын ажил 2012 оны төсөвт анх батлагдахдаа 2012-2014 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн ч 2014 оны төсөл, арга хэмжээний жагсаалтад багтаагүй буюу ямар нэгэн санхүүжилт хуваарилагдаагүйгээс тухайн жилдээ багтаж дуусаагүй ажээ. Улмаар шаардагдах санхүүжилтийг 2015, 2016 онд тусгалгүй орхигдуулж байгаад 2017 оны төсвийн тухай хуульд 2017 онд дуусгах төсөл, арга хэмжээ мэтээр дахин төсөвлөн оруулж ирсэн. Мөн гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажлыг 2014-2017 онд үргэлжлүүлэн гүйцэтгэхээр төлөвлөсөн ч 2015, 2016 оны төсөл, арга хэмжээний жагсаалтад уг ажил тусгагдаагүй байсан юм. Хэдийгээр зарим төсөл, арга хэмжээний хувьд тодорхой онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвлөлтөөс хасагдаж, концессын гэрээгээр барьж байгуулах, хөнгөлөлттэй зээл, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдэд тусгагдсан тохиолдол байсан ч алинд нь ч тусгагдалгүй орхигдож байсан буюу тодорхой жилүүдэд санхүүжилт нь тасарч байсан төсөл, арга хэмжээ 2017 оны хувьд гэхэд л нийт шилжсэн 342 төсөл, арга хэмжээнээс 156 байна (Дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос үзнэ үү). Ингэж **төсөл, арга хэмжээ зарим оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад багталгүй жил өнжих нь улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээ хугацаандаа дуусдаггүй, он дамжин хойшлох үндсэн шалтгаануудын нэг болж буй юм.**

Зураг төсөлтэй байх шаардлагын хэрэгжилт: Үндэсний аудитын газраас гаргасан “Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-аас үзэхэд шаардлагатай зураг төсөл нь боловсруулагдаагүй төсөл, арга хэмжээ төсөвт нэлээд тусжээ. Мөн алдаатай зураг төслийг баталснаас шалтгаалан төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан тохиолдлууд гарчээ (Дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас үзнэ үү). Тухайлбал, 2017 онд батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүд дунд анхнаасаа зураг төслийг

нь боловсруулалгүйгээр тусгасан, мөн төсөв батлагдсаны дараа зураг төслийг нь боловсруулах ажлын тендер зарлагдсан төсөл, арга хэмжээ 8 байв. Тухайлбал, Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байршилтай Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн харьяа Түлэнхийн төвийн барилга, Өмнөговь аймгийн Даланзадгад суманд байрлах Говийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилга, Дорнод аймгийн Хэрлэн суманд байршилтай Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр гэх зэрэг төсөл, арга хэмжээ 2017 оны төсвийн тухай хууль батлагдсан цаг хугацаанаас хойш зураг төслийг нь боловсруулах ажлын тендер нь зарлагджээ.

Түүнчлэн хийгдсэн зураг төсөлд зохих магадлал хийлгээгүй талаар Үндэсний аудитын газрын дүгнэлт гарсан 8 төсөл, зураг төсөл нь алдаатай хийгдсэнээс үүдэн хэрэгжилт удааширсан, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эхнээс нь гүйцэтгэх шаардлага үүссэн 5 төсөл, хэрэгжүүлэх арга хэмжээ нь тодорхойгүй, багц дүнгээр тусгагдсан бөгөөд шаардлагатай зураг төсөл, төлөвлөлт нь хийгдээгүй 4 арга хэмжээ байжээ. Жишээлбэл, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байршилтай Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилгын зураг төсөлд магадлал хийгдээгүй байсан бол Орхон аймгийн Баян-Өндөр суманд байрлалтай Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны зураг төсөл алдаатай хийгдсэнээс хэрэгжилт удааширсан тухай “Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд дурджээ. Тус зургийн зохиогч ажлын зурагт өрөөний тодорхойлолтыг давхар бүрийн байгуулалтад тодорхойлоогүй, хийц хэрэглэлүүдийг тодорхой заагаагүй, өндөржилтийн талаар тайлбар бэлтгэж оруулаагүй байсан байна. Эдгээр төслөөс гадна зураг төсөл нь хийгдсэн эсэхийг мэдээллийн олдоцгүй байдлаас шалтгаалан тодорхойлох боломжгүй олон төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 4. 2017 оны төсвийн хөрөнгө оруулалт: Зураг, төсөв нь алдаатай хийгдсэн төсөл, арга хэмжээ

№	Алдааны төрөл	Төслийн тоо
1	Зураг төслийг боловсруулаагүй тусгагдсан, төсөв батлагдсаны дараа зураг төсөл боловсруулах ажлын тендерийг зарласан	8
2	Хийлгэсэн зураг төсөлд магадлал хийлгүүлээгүй	8
3	Зураг төсөл алдаатай хийгдсэнээс үүдэн хэрэгжилт удааширсан	5
4	Хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй, багц дүнгээр тусгагдсан бөгөөд шаардлагатай зураг төсөл, төлөвлөлт хийгдээгүй	4
5	Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд зураг төслийг өөрчилж, төсөвт өртгийг нэмэгдүүлсэн	1

Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, “Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан (open.audit.mn), Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)

Техник эдийн засгийн үндэслэл, техник эдийн засгийн урьдчилсан судалгаа хийлгэсэн байх шаардлагын хэрэгжилт: 2017 оны улсын төсөвт батлагдсан нийт 373 төсөл, арга хэмжээнээс техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), судалгаа тооцоолол шаардлагатай төсөл, арга хэмжээнүүд нь холбогдох үнэлгээ, судалгааг

гүйцэтгэсэн эсэхийг олон нийтэд нээлттэй мэдээлэлд үндэслэн судалгааны багаас шалгахад холбогдох судалгаа, төлөвлөлтийг бүрэн хийлгэсэн 6 төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал, Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт байршилтай “Буянт-Ухаа” орон сууцны хорооллын 20,000 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил болон Улаанбаатар хотын гудамж төслийн хяналтын зөвлөх үйлчилгээ зэрэг төсөл, арга хэмжээ зохих төлөвлөлтийг бүрэн хийлгэжээ.

Хүснэгт 5. 2017 оны төсвийн хөрөнгө оруулалт: Холбогдох үнэлгээ, судалгааг дутуу хийлгэсэн төсөл, арга хэмжээ

№	Алдааны төрөл	Төслийн тоо
1	Төсөл, арга хэмжээний судалгаа, тооцоолол, төлөвлөлт дутуу эсвэл буруу хийгдсэнээс үүдэн хойшилсон, төсөвт өртөг нэмэгдсэн, дахин хэрэгжүүлэх шаардлага үүссэн арга хэмжээ	9
2	Төлөвлөлт алдаатай буюу төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй гэрээний хугацаа төлөвлөсөн	8
3	Төсвийн тухай хуулийн шаардлагад нийцүүлсэн, төлөвлөсөн эсэхийг тодорхойлох боломжгүй	6
4	Газар, гадна инженерийн дэд бүтцийг шийдэлгүйгээр батлан, хэрэгжүүлэх боломжгүй болсон төсөл, арга хэмжээ	5
5	Бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй, төлөвлөлт, тооцоолол дутуу төсөл, арга хэмжээг зөрчлийг нь арилгалгүйгээр дахин төсөвт тусгасан	4
6	Арга хэмжээг хэрэгжүүлж дуусгалгүйгээр хариуцагчийг сольсон, хүчингүй болгосон	3
7	Холбогдох судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажлын тендер төсөвт арга хэмжээ батлагдсаны дараа зарлагдсан буюу шаардлагатай судалгааг хийлгүйгээр баталсан арга хэмжээ	2

Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, “Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан (open.audit.mn), Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)

2017 онд батлагдсан хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад төсөл, арга хэмжээний судалгаа, тооцоолол, төлөвлөлт дутуу эсвэл алдаатай хийгдсэнээс үүдэн хойшлогдсон, дахин төлөвлөгдсөн, төсөвт өртөг нь нэмэгдсэн нийт 9 төсөл, арга хэмжээ, Үндэсний аудитын газраас бэлтгэл ажил хангаагүй, төлөвлөлт, тооцоолол дутуу гэсэн дүгнэлтийг гаргасан хэдий ч холбогдох зөрчлийг нь арилгалгүйгээр дахин улсын төсөвт тусгасан 4 арга хэмжээ, төлөвлөлтийн алдаанаас үүдэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дуусгах боломжгүй хугацааг анхнаас нь тавьсан 8 арга хэмжээ, холбогдох ТЭЗҮ, судалгаа, тооцооллыг хийх тендер төсөв батлагдсаны дараагаар зарлагдсан буюу судалгаа, тооцоолол байхгүй 2 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, Төсвийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэхэд дүгнэлт өгөх, тодорхойлох боломжгүй 6 төсөл, арга хэмжээ тус тус байсан. Түүнчлэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дуусалгүйгээр хариуцагчийг сольсон эсхүл хэрэгжилтийг хүчингүй болгосон нийт 3 төсөл, арга хэмжээ 2017 оны төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад тусжээ. Тодруулбал, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт байршилтай Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг “Өнөр” хорооллын 33 дугаар байрны арын замтай холбох 1 км авто

замын барилгын ажил, Булган аймгийн Булган суманд байрлалтай 640 суудалтай сургуулийн барилга, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зээлээр хэрэгжих “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам” төслийн аймаг дундын Өлгий-Ховд чиглэлийн авто замын үргэлжлэл хатуу хучилттай 189.7 км авто замын ажлууд хариуцагч солигдсон болон хүчингүй болгосон шалтгаанаар хэрэгжээгүй байна.

Газрын зөвшөөрөлтэй байх шаардлагын хэрэгжилт: Үндэсний аудитын газрын “Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-д газрын зөвшөөрөл аваагүй, гадна инженерийн дэд бүтцийн асуудлыг шийдэлгүйгээр төсвийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх боломжгүй болсон 5 арга хэмжээг дурдсан. Жишээлбэл, Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байршилтай Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний барилга газрын зөвшөөрөлгүй байсны улмаас байршлыг нь сольсон байна. Мөн Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ)-ны цахим хуудсанд тавигдсан мэдээллээр Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байршилтай АХБ-ны санхүүжилтээр хэрэгжих “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх” төсөл газрын асуудлаа шийдвэрлээгүй байсан тул хэрэгжилт нь удааширсан⁴ гэсэн бол гүйцэтгэлийн аудитын тайланд хэрэгжилт дутуу байгаа шалтгааныг санхүүжилт хугацаандаа олгогдоогүй гэжээ.

Хүчин чадал, байршлыг тусгах шаардлагын хэрэгжилт: Төсвийн тухай хуулийн 33.2.6-д төсөвт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлахдаа нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн зэргийг тусгах тухай заасан байдаг бөгөөд 2017 онд батлагдсан төсөвт дээрх мэдээллийг оруулаагүй зөрчилтэй баталсан төсөл, арга хэмжээ нэлээд байв. Тухайлбал, хүчин чадлыг нь тодорхойлох боломжтой нийт 303 төсөл, арга хэмжээ байсны 45 хувьд нь хүчин чадлыг тусгасан байсан бол үлдсэн 55 хувьд нь төслийн хүчин чадлыг тодорхойлолгүй баталжээ. Тухайлбал, XI.1.44 хуулийн дугаартай “Цэвэр, бохир усны шугам сүлжээ, усан сан, насосын станц, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт (Улаанбаатар, Багахангай дүүрэг)”, XII.1.1.49 хуулийн дугаартай “Сургуулийн барилга (Сэлэнгэ, Сант сум)” гэх зэрэг төсөл, арга хэмжээг дурдаж болох юм. Мөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байршлыг нийт төсөл, арга хэмжээний 85 хувьд нь тусгасан байсан бол 13 хувьд нь улсын хэмжээнд, аймгийн хэмжээнд гэх зэргээр ерөнхий тусгасан байхад 2 хувьд нь байршлыг огт тусгаагүй байв. Жишээлбэл, VII.1.1.1 хуулийн дугаартай “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт”-ын байршлыг улсын хэмжээнд, XI.1.19 хуулийн дугаартай “Цэвэр, бохир усны итгэмжлэгдсэн болон зөөврийн лаборатори байгуулах” төсөл, арга хэмжээний байршлыг орон нутагт гэж ерөнхий тусгасан байв.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хуваарилалтад тавигдах шаардлагын хэрэгжилт: Төсвийн тухай хуулийн 29.3.5-т заасан “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож санхүүжүүлэх” шаардлагыг 2017 онд шинээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүд бүрэн хангасан байна.⁵ Харин 2017

4 “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН2719/0240 төсөл”-ийн хэрэгжилтийн тайлан (2018 оны жилийн эцсийн байдлаар), Зам, тээврийн хөгжлийн яам.

5 Төсвийн тухай хуульд 2023 оны 7-р сарын 7-ны өдөр оруулсан нэмэлт хамаарахгүй.

оноос өмнө батлагдсан буюу шилжсэн төслүүдийн хувьд анх батлагдсан хугацаатай нь тулгалт хийж харьцуулахад тус шаардлагыг хангаагүй нийт 165 төсөл, арга хэмжээ байсан бөгөөд өндөр төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнүүдэд тухайн төсвийн жилд маш бага дүнтэй санхүүжилт төсөвлөсөн тохиолдол их байв. Энэ нь төсөл, арга хэмжээнүүд хугацаандаа дуусалгүй, он дамжин шилжихэд нөлөөлдөг гол хүчин зүйлсийн нэг юм.

Төсөл нэг бүрийг тусгах шаардлагын хэрэгжилт: Төсвийн тухай хуулийн 29.3.4-т “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” гэж заасан байдаг ч олон тооны төсөл, арга хэмжээг нэгтгэн төлөвлөх, ерөнхий утгаар тусгах, хэрэгжүүлэх арга хэмжээ нь тодорхой бус төсөл, арга хэмжээ батлах тохиолдол цөөнгүй гарчээ. 2017 онд нийт 47 төсөл, арга хэмжээнд олон тооны төсөл, арга хэмжээг багцлан тусгасан байсан нь эдгээр төсөл, арга хэмжээний хүчин чадал, байршлыг нарийн тодорхойлох, шаардлагатай зураг төсөл, төлөвлөлтийг урьдчилан гүйцэтгэсэн эсэхийг тодорхойлоход хүндрэлтэй болгосон. Жишээлбэл, байршлыг нь улсын хэмжээнд гэж төлөвлөсөн нийслэл, аймгуудад байршилтай орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ гэх төсөл, арга хэмжээ нь нэгтгэн төлөвлөгдсөн байгаа бол Эрчим хүчний сайдын багцад тусгагдсан дулааны цахилгаан станц, дулааны шугам, сүлжээ гэх төсөл, арга хэмжээ нь ямар ч байршил заагаагүйн дээр хэрэгжүүлэх арга хэмжээ нь тодорхой бус байгаа юм.

Бусад төрлийн зөрчилтэй төсөл, арга хэмжээ: Үндэсний аудитын газрын дүгнэлт, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем зэрэг нийтэд ил тод байдаг мэдээллийн эх сурвалжаас шалгахад 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөвт хэрэгжүүлж дууссан хэдий ч дахин төсвийн төлөвлөлтөд оруулж, нэмэлт төсөв тусгуулсан, бодит ажлын гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үед гарсан зөрчил маргаантай холбоотой ханшийн зөрүү, хүү, торгуулийн төлбөрийг төслийн төсөвт өртөгт тусгасан зэрэг тохиолдлууд мөн байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн Баянбулаг суманд байршилтай 10 ортой сумын эрүүл мэндийн төвийн барилгын зураг төслийг ажлын явцад өөрчилж, төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байх жишээтэй. Түүнчлэн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг байршилтай Ахуй үйлчилгээний уулзварын зам, барилгын ажлыг 2014 онд “Гудамж” төслийн хүрээнд гүйцэтгэж дууссан тухай мэдээлэл байсан ч 2015, 2017 оны батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтад дахин оруулсан байна.

Хүснэгт 6. Бусад төрлийн зөрчилтэй төсөл, арга хэмжээ

№	Зөрчлийн төрөл	Төслийн тоо
1	Ажил гүйцэтгэгч тал хугацаандаа нийлүүлээгүйн улмаас хэрэгжилт хойшилсон	30
2	Худалдан авах ажиллагаа зарлагдажгүй удаж хугацаа алдсан	27
3	Төсөвт өртөг бүрэн санхүүжигдэж туссан ч дахин төсвийн төлөвлөлтөд орсон, нэмэгдсэн төсөвт өртгийн зарцуулалт тодорхой бус арга хэмжээ	8
4	Санхүүжилт хугацаандаа олгогдоогүйн улмаас хугацаандаа хэрэгжээгүй арга хэмжээ	7
5	Бодит ажлын гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон	4

6	Аль хэдийн хүлээлгэн өгсөн ч төсвийн төсөлд дахин тусгагдсан арга хэмжээ	3
7	Ханшийн зөрүү, хүү, торгуулийн төлбөрийг төсөвт өртөгт тусгасан	3
8	Өмнөх онуудад хэрэгжсэн арга хэмжээн дээр шинэ арга хэмжээ нэмж шилжих төсөл болгон батлуулсан	1

Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, "Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан (open.audit.mn), Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)

Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд байгаагүй буюу УИХ-аас төсөв хэлэлцэх явцад нэмсэн төсөл, арга хэмжээ: Засгийн газрын өргөн мэдүүлсэн 2017 оны төсвийн төсөлд багтаагүй хэдий ч Улсын Их Хурал(УИХ)-ын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдэн орж батлагдсан дараах 4 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- УИХ-ын даргын багцад хамаарах 1,688 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Улсын Их Хурлын техник, тоног төхөөрөмж худалдан авах" арга хэмжээ;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад хамаарах 2,970 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга (Баянхонгор, Баянхонгор сум) байгуулах" арга хэмжээ (тус арга хэмжээ нь 2011 оноос хойш шилжиж буй төсөл);
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад хамаарах 4,200 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хүнс, барааны худалдааны төвийн барилга (Хөвсгөл, Мөрөн сум) байгуулах" арга хэмжээ (тус арга хэмжээ нь 2012 оноос хойш шилжиж буй төсөл);
- Эрүүл мэндийн сайдын багцад хамаарах 2,100 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хавдар судлалын үндэсний төвийн сити томографын аппарат /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/" (тус арга хэмжээ нь 2016 оноос хойш шилжиж буй төсөл).

2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд нийт 1,281 төсөл, арга хэмжээнд 1.55 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор баталснаас 373 буюу 29.1 хувь нь шилжсэн, 908 буюу 70.9 хувь нь шинээр тусгагдан батлагдсан төсөл, арга хэмжээ байжээ. Шилжсэн төсөл, арга хэмжээнүүдэд батлагдсан нийт төсвийн 31.6 хувь буюу нийт 490.4 тэрбум төгрөгийн төсөв хуваарилагдсан.

Хүснэгт 7. 2019 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт анх туссан оноор

№	Төсөвт анх туссан он	Шилжсэн төслийн тоо	Нийт шилжсэн төсөлд эзлэх хувь
1	2007-2012 онд анхлан туссан төсөл	24	6.4
2	2013 оноос хойш шилжиж буй	6	1.6
3	2014 оноос хойш шилжиж буй	4	1.1
4	2015 оноос хойш шилжиж буй	1	0.3
5	2016 оноос хойш шилжиж буй	5	1.3
6	2017 оноос хойш шилжиж буй	2	0.5
7	2018 оноос хойш шилжиж буй	331	88.7

Эх сурвалж: Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль

2019 онд батлагдсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжаас зөвхөн тус онд шинээр батлагдсан нийт 908 төсөл, арга хэмжээний хувьд зохих шаардлагыг хэрхэн хангасан талаар судалж, үр дүнг дор тайлагнаж байна.

Зураг төсөл, төлөвлөлт, судалгаа хийгдсэн байх шаардлагын хэрэгжилт: Төсөл, арга хэмжээний батлагдсан жагсаалт, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем зэрэг нийтэд ил тод байдаг мэдээллийн эх сурвалжаас шалгахад 908 төсөл, арга хэмжээний 645 төсөл, арга хэмжээний зураг төслийг боловсруулах шаардлагатай байжээ. Үүнээс 70.2 хувь буюу 453 төсөл, арга хэмжээ шаардлагатай зураг төслийг боловсруулж, тендерийн баримт бичигт хавсаргасан байсан бол 8.7 хувь буюу 56 арга хэмжээ нь зураг төслийг боловсруулалгүйгээр тухайн арга хэмжээг гүйцэтгэх ажлын тендерт холбогдох зураг төслийг боловсруулах ажлын даалгаврыг хавсарган зарласан, үлдсэн 21.1 хувь буюу 136 төсөл, арга хэмжээ зураг төсөлгүй байсан (Дэлгэрэнгүйг Хавсралт 4, 5-аас үзнэ үү). Жишээлбэл, Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд байршилтай багийн төвийн барилгууд зураг төсөлтэй эсэх нь тодорхойгүй байсан бол Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байрлах залуучуудын хөгжлийн төв, Дархан-Уул аймгийн Дархан суманд байршилтай үерийн далан, сувгийн байгууламж зэргийн барилгын ажлыг гүйцэтгэх тендерийг зураг төслийг нь боловсруулах ажлын даалгавартай хамтатган зарласан байна.

Төслийн хүчин чадал, байршлыг тусгах шаардлагын хэрэгжилт: Хүчин чадлыг нь тодорхойлох боломжтой нийт 660 төсөл, арга хэмжээний 43.2 хувьд хүчин чадлыг тусгасан бол үлдсэн 56.8 хувийнх нь хүчин чадлыг тусгаагүй байсан. Тухайлбал, IX.3.1.1 хуулийн дугаартай “Хөгжил политехник коллежийн барилга (Ховд, Жаргалант сум),” X.1.3 хуулийн дугаартай “Оюутан цэрэг хөтөлбөрийн хүрээнд баригдах цэргийн байр (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)” зэрэг төсөл, арга хэмжээг нэрлэж болох юм. Мөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байршлыг нийт төсөл, арга хэмжээний 95.9 хувьд нь тодорхойлсон байсан бол 4 хувьд нь улсын хэмжээнд, аймгийн хэмжээнд гэх зэргээр ерөнхий тусгасан, 0.1 хувьд нь байршлыг огт тусгаагүй байжээ. Жишээ нь, XI.1.11 хуулийн дугаартай “Нийслэл, аймгийн төвийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт (улсын хэмжээнд), XI.1.20 хуулийн дугаартай “Хог ангилах

төвийн барилга, тоног төхөөрөмж (Улаанбаатар)” гэх зэрэг төсөл, арга хэмжээний байршил тодорхой биш байгаа юм.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хуваарилалт: Төсвийн тухай хуулийн 29.3.5-т заасан шаардлагыг 2019 онд шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний 18.5 хувь буюу 168 нь хангаагүй байна. Жишээлбэл, Завхан аймгийн Улиастай суманд байршилтай мэргэжлийн хяналтын газрын лабораторийн болон конторын барилгын хувьд 2 жилд хэрэгжих төлөвлөлттэйгөөр тусгагдсан тул 2019 онд санхүүжилтийн 50 хувиас багагүйг хуваарилах ёстой байтал дөнгөж 27 хувийн санхүүжилтийг хуваарилсан. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах чөлөөт бүсийн дохиолол, хамгаалалтын нэгдсэн системийн ажил 3 жилийн хугацаанд хэрэгжихээр төлөвлөгдсөн байтал 2019 онд ердөө 9 хувийн санхүүжилтийг хуваарилсан байх жишээтэй.

Төсөвт төсөл нэг бүрийг тусгах шаардлагын хэрэгжилт: Олон тооны төсөл, арга хэмжээг нэгтгэн төлөвлөсөн, нарийвчлан хэрэгжүүлэх арга хэмжээ нь тодорхой бус 11 төсөл, арга хэмжээ байв. Тухайлбал, Завхан аймгийн Улиастай суманд байршилтай “Баазын район, ХААУДҮГ, 8 дугаар цэцэрлэг, 9 дүгээр цэцэрлэгийн усан хангамж, ариутгах татуургын угсралтын ажил, багуудын бохирын болон дулааны шугам сүлжээ” гэсэн төсөл нь олон байршлыг хамтатган төлөвлөснөөс гадна хэд, хэдэн ажлыг нэгтгэн тусгасан байна. Ховд аймгийн Булган суманд төлөвлөсөн “Усжуулалтын суваг, шуудуу, услалтын систем, гүүрний бүтээн байгуулалт” гэсэн ажил нь услалтын систем, гүүрний бүтээн байгуулалт зэрэг хэд, хэдэн төсөл, арга хэмжээг нэгтгэн төлөвлөжээ.

2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд нийт 1,100 төсөл, арга хэмжээнд 1.4 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор баталснаас 640 буюу 58 хувь нь шилжсэн төсөл, 460 нь шинээр тусгагдан батлагдсан арга хэмжээ байсан. Эдгээр шилжсэн төсөл, арга хэмжээнд батлагдсан нийт төсвийн 65 хувь буюу 914.7 тэрбум төгрөгийн төсөв хуваарилагджээ.

Хүснэгт 8. 2021 оны улсын төсөвт шилжин тусгаагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт анх туссан оноор

№	Төсөвт анх туссан он	Шилжсэн төслийн тоо	Нийт шилжсэн төсөлд эзлэх хувь
1	2010-2014 онд анхлан туссан төсөл	20	3.1
2	2015 оноос хойш шилжиж буй	2	0.3
3	2016 оноос хойш шилжиж буй	2	0.3
4	2017 оноос хойш шилжиж буй	0	0.0
5	2018 оноос хойш шилжиж буй	52	8.1
6	2019 оноос хойш шилжиж буй	138	21.6
7	2020 оноос хойш шилжиж буй	426	66.6

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль

2021 онд батлагдсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжаас зөвхөн тус онд шинээр батлагдсан нийт 460 төсөл, арга хэмжээний хувьд төсөвлөлтийн зохих шаардлагыг хэрхэн хангасан талаар дор авч үзлээ.

Зураг төсөл, төлөвлөлт судалгаа хийгдсэн байх шаардлагын хэрэгжилт: Төсөл, арга хэмжээний батлагдсан жагсаалт, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем зэрэг нийтэд ил тод байдаг мэдээллийн эх сурвалжаас судалгааны баг шалгахад 460 төсөл, арга хэмжээнээс зураг төсөл боловсруулах шаардлагатай нийт 309 арга хэмжээ байна. Үүнээс 63.1 хувь буюу 195 төсөл, арга хэмжээ шаардлагатай зураг төслийг боловсруулж, тендерийн баримт бичигт хавсаргасан бол 20.7 хувь буюу 64 арга хэмжээ нь зураг төслийг боловсруулалгүйгээр тухайн арга хэмжээг гүйцэтгэх ажлын тендерт холбогдох зураг төслийг боловсруулах ажлын даалгаврыг хавсарган зарласан, үлдсэн 16.2 хувь буюу нийт 50 арга хэмжээ зураг төсөлгүй байв (Дэлгэрэнгүйг Хавсралт 6, 7-оос үзнэ үү). Жишээлбэл, VI.1.14 хуулийн дугаартай “Соёмбо цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/”, XI.1.1.8 хуулийн дугаартай “Хүүхдийн парк байгуулах /Дорноговь, Сайншанд сум, 3 дугаар баг/” гэх зэрэг төсөл, арга хэмжээг дурдаж болно.

Хүснэгт 9. 2021 оны төсвийн хөрөнгө оруулалт: Шинээр батлагдсан төсөл арга хэмжээний зураг, төсөв боловсруулсан байдал

№	Зураг төсөл боловсруулагдсан байдал	Төслийн тоо
1	Зураг төслийг боловсруулж, тендерийн баримт бичигт хавсаргасан	195
2	Зураг төсөл боловсруулах даалгаврыг ажил гүйцэтгэх тендертэй хамт зарласан	64
3	Зураг төсөлгүй	50

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)

Төслийн хүчин чадал, байршлыг тусгах шаардлагын хэрэгжилт: Хүчин чадлыг нь тодорхойлох боломжтой нийт 280 төсөл, арга хэмжээ 2021 оны төсөвт батлагдсанаас 28.6 хувьд нь хүчин чадлыг тусгасан бол үлдсэн 71.4 хувьд нь төслийн хүчин чадлыг тусгалгүй баталжээ. Мөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байршлыг нийт төсөл, арга хэмжээний 87.2 хувьд нь тусгасан байсан бол 12.4 хувь нь улсын хэмжээнд, аймгийн хэмжээнд гэх зэргээр ерөнхий тусгасан, 0.4 хувь нь байршлыг огт тусгаагүй байв. Тухайлбал, XI.1.1.4 хуулийн дугаартай “Хүүхдийн зуслан байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээний байршлыг зөвхөн Дорноговь гэж тусгасан бол XIII.1.1.83 хуулийн дугаартай “Сургуулийн барилгын өргөтгөл (Архангай, Хашаат сум)” төсөл, арга хэмжээний хүчин чадал буюу суудлыг тусгаагүй байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хуваарилалт: Төсвийн тухай хуулийн 29.3.5-т заасан шаардлагыг 2021 онд шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний 41.3 хувь буюу 190 нь хангаагүй. Шаардлага хангаагүй зарим төсөл, арга хэмжээнээс дурдвал Архангай аймгийн Эрдэнэбулган суманд байршилтай спортын ордны барилгыг 3 жилд барихаар төлөвлөсөн хэр нь 2021 онд дөнгөж 6 хувийн санхүүжилт хуваарилсан байсан бол Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт байрлах хөл

бөмбөгийн талбай бүхий спортын цогцолборыг 2 жилд байгуулахаар төлөвлөөд өрдөө 20 хувийн санхүүжилт хуваарилсан байх жишээтэй.

Төсөвт төсөл нэг бүрийг тусгах шаардлагын хэрэгжилт: Төсвийн тухай хуулийн 29.3.4-т “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” гэж заасан байдаг ч 2021 онд шинээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүдийн дунд олон тооны арга хэмжээг нэгтгэн төлөвлөсөн, нарийвчлан хэрэгжүүлэх арга хэмжээ нь тодорхой бус 8 төсөл, арга хэмжээ байв. Жишээлбэл, Өвөрхангай аймаг гэсэн байршил заасан “Төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд компьютер, тоног төхөөрөмж, автомашин нийлүүлэх”, улсын хэмжээнд хэрэгжинэ гэж төлөвлөсөн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын харьяа Мал эмнэлгийн лабораторийн болон Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилга, дулаан, сантехник, гадна, дотно инженерийн шугам сүлжээний их засвар” гэх зэрэг төсөл, арга хэмжээнүүд нь төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах гэсэн шаардлагыг илэрхий хангахгүй байгаа юм.

2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 1,369 төсөл, арга хэмжээнд 1.39 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор баталснаас 705 буюу 52 хувь нь шилжсэн төсөл, 664 буюу 48 нь шинээр тусгагдан батлагдсан арга хэмжээ байна. Эдгээр шилжсэн төсөл, арга хэмжээнд батлагдсан нийт санхүүжилтийн 60 хувь буюу нийт 834.7 тэрбум төгрөгийн төсөв хуваарилагджээ. Шилжсэн төсөл, арга хэмжээнүүдийг авч үзэхэд 2010 оноос эхлэн төсөвт тусгагдсан буюу нийт 13 жил дамнасан төсөл, арга хэмжээ хүртэл байна. Тухайлбал, Улаанбаатар хотын Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт тус тус байршилтай 1,000 хүний суудалтай дүүргийн спорт цогцолбор, Дархан-Уул аймгийн Дархан суманд байрлах 2,200 хүний суудал бүхий спорт цогцолбор зэргийг дурдаж болно.


Хүснэгт 10. 2022 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт анх туссан оноор

№	Төсөвт анх туссан он	Шилжсэн төслийн	Нийт шилжсэн
		тоо	төсөлд эзлэх хувь
1	2010-2014 онд анхлан туссан төсөл	26	3.7
2	2015 оноос хойш шилжиж буй	1	0.1
3	2016 оноос хойш шилжиж буй	1	0.1
4	2017 оноос хойш шилжиж буй	1	0.1
5	2018 оноос хойш шилжиж буй	70	9.9
6	2019 оноос хойш шилжиж буй	151	21.4
7	2020 оноос хойш шилжиж буй	214	30.4
8	2021 оноос хойш шилжиж буй	241	34.2

Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль

2022 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээг үргэлжилж буй жилээр нь авч үзвэл 6-аас дээш жил үргэлжилж буй төсөл 29 байгаа бол 5 жил үргэлжилж буй төсөл 70 байна (Зураг 3).

Зураг 3. 2022 оны улсын төсөвт шилжин тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, үргэлжилж буй жилээр



Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль

2022 онд батлагдсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжаас зөвхөн тус онд шинээр батлагдсан нийт 664 төсөл, арга хэмжээний хувьд төсөвлөлтийн зохих шаардлагыг хэрхэн хангасныг судалж, үр дүнг дор тайлагнаж байна.

Зураг төсөлтэй байх шаардлагын хэрэгжилт: Судалгааны баг төсөл, арга хэмжээний батлагдсан жагсаалт, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем зэрэг нийтэд ил тод байдаг мэдээллийн эх сурвалжаас шалгахад 664 төсөл, арга хэмжээнээс зураг төсөл боловсруулах шаардлагатай нийт 451 арга хэмжээ байсны 73.8 хувь буюу 333 төсөл, арга хэмжээ шаардлагатай зураг төслийг боловсруулж, тендерийн баримт бичигт хавсаргасан бол 10 хувь буюу 45 арга хэмжээ нь зураг төслийг боловсруулалгүйгээр тухайн арга хэмжээг гүйцэтгэх ажлын тендерт холбогдох зураг төслийг боловсруулах ажлын даалгаврыг хавсарган зарласан, үлдсэн 16.2 хувь буюу нийт 73 төсөл, арга хэмжээ шаардлагатай зураг төсөлгүй байсан (Дэлгэрэнгүйг Хавсралт 8, 9-өөс үзнэ үү). Жишээлбэл, XII.1.162 хуулийн дугаартай “Цэвэр усны нөөц сан (Дорноговь)”, XIII.1.1.248 хуулийн дугаартай “Багшийн хөгжлийн төвийн барилга (Ховд, Жаргалант сум)” гэх зэрэг төсөл, арга хэмжээг дурдаж болно.

Хүснэгт 11. 2022 оны төсвийн хөрөнгө оруулалт: Шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулсан байдал

№	Зураг төсөл боловсруулагдсан байдал	Төслийн тоо
1	Зураг төслийг боловсруулан тендерийн баримт бичигт хавсаргасан	333
2	Зураг төсөл боловсруулах даалгаврыг ажил гүйцэтгэх тендертэй хамт зарласан	45
3	Зураг төсөлгүй	73

Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)


Зураг 4. 2022 оны төсвийн хөрөнгө оруулалт: Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулаагүй батлагдсан төсөл, арга хэмжээний тоо, салбараар



Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)

Зураг төсөл, ТЭЗҮ-гүй төсөл, арга хэмжээг салбарын ангиллаар авч үзвэл барилгын салбар хамгийн өндөр буюу 20.3 хувийг эзэлсэн бол удаад нь боловсрол, зам тээврийн салбарууд байна.

Зураг 5. 2022 оны төсвийн хөрөнгө оруулалт: Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулаагүй батлагдсан төсөл, арга хэмжээ, байршлаар



Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)

2022 онд шинээр батлагдсан төсөл арга хэмжээнээс холбогдох зураг төсөл, ТЭЗҮ-ийг боловсруулалгүй батлагдсан нийт 73 төсөл, арга хэмжээний 76.8 хувийг орон нутагт хэрэгжүүлэх, 15.9 хувийг Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тус тус эзэлж байна.

Төлөвлөлт, судалгаа, ТЭЗҮ хийгдсэн байх шаардлагын хэрэгжилт: ТЭЗҮ, урьдчилсан судалгаа шаардлагатай нийт 227 төсөл, арга хэмжээ байснаас 69.6 хувь буюу 158 нь холбогдох судалгаа, ТЭЗҮ хийлгэсэн бол үлдсэн 30.4 хувь буюу 69 төсөл, арга хэмжээнд шаардлагатай судалгаа, үнэлгээ хийлгүйгээр баталжээ. Хачирхалтай нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцад хамаарах XIII.1.1.234 хуулийн дугаартай “960 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах (Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Нарны хороолол)” төсөл нь 2019 оны улсын төсөвт XII.1.1.227 хуулийн дугаартайгаар аль хэдийн тусгагдаж, холбогдох худалдан авах үйл ажиллагааны тендер нь тус онд зарлагдсан байсан хэдий ч 2022 оны төсөвт шинэ төсөл, арга хэмжээ мэтээр дахин тусгагдсан байсан. Түүнчлэн төсөл, арга хэмжээг гүйцэтгэх тендерийг оройтож зарласан 14 төсөл, арга хэмжээ байв (Дэлгэрэнгүйг Хавсралт 10-аас үзнэ үү).⁶ Жишээлбэл, Дорнод аймгийн Баян-Уул суманд байршилтай Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай 50 км авто замын тендер 2022 оны 7 дугаар сард зарлагдсан бол Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны 160 суудалтай сургуулийн хичээлийн байрны барилгын тендер 2022 оны 10 дугаар сард зарлагджээ.

Төслийн хүчин чадал, байршлыг тусгах шаардлагын хэрэгжилт: Хүчин чадлыг нь тодорхойлох боломжтой нийт 458 төсөл, арга хэмжээ 2022 оны төсөвт батлагдсанаас 34.7 хувь нь хүчин чадлыг тусгасан бол үлдсэн 65.3 хувь нь төслийн хүчин чадлыг тусгаагүй. Жишээлбэл, XIII.1.1.239 хуулийн дугаартай “Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга (Улаанбаатар, Багануур дүүрэг, 3 дугаар хороо)”, XIII.1.1.268 хуулийн дугаартай “Спорт заалны барилга (Дорнод, Хэрлэн сум, 1 дүгээр сургууль)” зэрэг төсөл, арга хэмжээ байна. Мөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байршлыг нийт төсөл, арга хэмжээний 84.2 хувьд нь тусгасан бол 15.5 хувьд нь улсын хэмжээнд, аймгийн хэмжээнд гэх зэргээр ерөнхий тусгасан, 0.3 хувьд нь байршлыг огт тусгаагүй. Тухайлбал, XIII.1.1.314 хуулийн дугаартай “Хоол үйлдвэрлэлийн байрны барилга, их засвар”, XIV.3.5 хуулийн дугаартай “Музейн камер болон дохиолол хамгааллын систем” зэрэг төсөл, арга хэмжээний байршлыг улсын хэмжээнд гэж тодорхойгүй тусгажээ.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хуваарилалтад тавигдах шаардлагын хэрэгжилт: Төсвийн тухай хуулийн 29.3.5-т заасан шаардлагыг 2022 онд шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний 67.3 хувь буюу 444 нь хангаагүй. Жишээ нь,

6 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлд зааснаар нээлттэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын 15-20-оос дээш өдөр байдаг бол мөн хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу тендерийн хүчинтэй байх хугацаа тендер нээснээс хойш ажлын 30-аас доошгүй өдөр байхаар заадаг. Энэхүү 50 ажлын өдрөөс гадна тендер үнэлэх, шийдвэр гаргах үйл явц удаашрах нь түгээмэл байдгаас тухайн төсвийн жилийн II хагаст зарлагдсан худалдан авах ажиллагаа ихэвчлэн ондоо багтаж дуусдаггүй байна.

Хэнтий аймгийн Норовлин суманд байршилтай Өндөрхаан-Норовлин чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл болох 130 км авто замын ажлын үргэлжлэх хугацааг 4 жил гэж төлөвлөсөн хэр нь 2022 онд төсөвт өртгийн 14 хувьтай тэнцэх санхүүжилт хуваарилсан байна. Мөн Төв аймгийн Угтаалцайдам суманд байршилтай Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км хатуу хучилттай авто замын ажлыг 3 жилд гүйцэтгэхээр төлөвлөсөн ч ердөө 12 хувийн санхүүжилт хуваарилжээ.

Төсөл нэг бүрийг тусгах шаардлагын хэрэгжилт: Төсвийн тухай хуулийн 29.3.4-т “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” гэж заасан байдаг ч төсөл, арга хэмжээний жагсаалтад олон тооны арга хэмжээг нэгтгэн төлөвлөсөн, нарийвчлан хэрэгжүүлэх арга хэмжээ нь тодорхой бус 14 төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал, Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт байршилтай “960 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах” гэсэн арга хэмжээ нь төсөл нэг бүрээр тусгах шаардлагыг хангаагүй бол “Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ” гэсэн төслийн байршлыг Хэнтий аймгийн Баян-Адрага, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум гэж нэгтгэн тусгасан байна.

5. Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотгол”-д нийт 54.6 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 149 төсөл, арга хэмжээ тусгагдсан. Санхүүжилтийн хуваарийн дагуу үүний 63.1 хувь буюу 34.4 их наяд төгрөгийг 2019-2021 онд санхүүжүүлэх бол 15.3 их наяд төгрөг буюу 27.9 хувь нь шилжих хуваарьтай байжээ. 149 төсөл, арга хэмжээний 19 (3.7 хувь)⁷ нь улсын төсвийн эх үүсвэртэй байсан бөгөөд төсөвт өртөг нь 2.02 их наяд төгрөг байсан. Холимог буюу гадаад зээл тусламж, улсын төсөв ба гадаад зээл тусламж, Хөгжлийн банкны эх үүсвэртэй 7.6 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ 20 байсан ч улсын төсвийн санхүүжилт нь харьцангуй бага, гадаад зээл, тусламжийн эх үүсвэр дээр хувь нэмэр оруулах байдлаар тусгагдсан байсан тул бид энэ удаагийн шинжилгээгээр зөвхөн улсын төсвийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээнүүдийг дэлгэрүүлэн авч үзлээ. Эдгээр улсын төсвийн эх үүсвэртэй 19 төсөл, арга хэмжээний хувьд санхүүжилтийг бүрэн зарцуулж, шилжих санхүүжилтгүй байхаар төлөвлөсөн буюу бүх төсөл, арга хэмжээг 2018-2021 онд хэрэгжүүлж дуусна гэсэн зорилготой байжээ.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн нийт 150 төсөл, арга хэмжээ тусгагдаж, төсөвт өртгийг нь 49.7 их наяд төгрөг байхаар тусгажээ. Үүнээс улсын төсвийн санхүүжилттэй 3.7 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 29 төсөл байна.

Зураг 6. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслийн тоо, эх үүсвэрийн төрлөөр




Эх сурвалж: Монгол Улсын 2018-2021, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

7 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтэд эх үүсвэрийн эзлэх хувь

Хоёр хөтөлбөрийг харьцуулахад нийт төсөл, арга хэмжээний тоо үндсэндээ ижил байгаа ба гадаад зээл, тусламжийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээний тоо 2021-2025 онд нэмэгдсэн. Харин эх үүсвэр нь концесс байх төсөл, арга хэмжээний тоо буурсан бол холимог болон Хөгжлийн банкны эх үүсвэртэй төсөл, арга хэмжээний тоо төдий л өөрчлөгдөөгүй байна.

Зураг 7. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөвт өртөг, эх үүсвэрийн төрлөөр, их наяд төгрөг



Эх сурвалж: 2018-2021, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Төсөвт өртгийн хувьд гадаад зээл, тусламж, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ), Хөгжлийн банкны эх үүсвэртэй төсөл, арга хэмжээнүүд голлосон хэвээр байна. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт санхүүжилтийн эх үүсвэр нь шийдвэрлэгдээгүй төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 14.3 их наяд төгрөг байсан бол 2021-2025 онд эх үүсвэр амлагдаагүй болон шийдвэрлэгдээгүй төсөл, арга хэмжээ тусгагдаагүй нь сайшаалтай. Харин эх үүсвэр нь хэсэгчлэн шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь 3.1 их наяд байгаа юм.

Хүснэгт 12. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголд тусгагдсан улсын төсвийн эх үүсвэртэй төслүүд

№	Төслийн нэр	Төсөвт өртөг (тэрбум төгрөг)	Харгалзах оны улсын төсөвт тусгагдсан дүн (тэрбум төгрөг)			2021-2025 оны хөтөлбөрт шилжин тусгагдсан эсэх
			2019 он	2020 он	2021 он	
1	Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх	35.0	7.5	5.97	-	Үгүй
2	Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр	545.4	217.9	159.9	180.2	Тийм
3	Хүүхэд бүрд цэцэрлэг хөтөлбөр	277.8	180.6	59.3	79.4	Тийм
4	Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам /Концессын эргэн төлөлт/	147.9	28.0	31.99	Тусгаг-даагүй	Үгүй
5	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам /Концессын эргэн төлөлт/	222.8	42.2	53.9	Тусгаг-даагүй	Үгүй
6	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км авто зам	80.1	0.68	-	-	Үгүй
7	Инженерийн рот	40.3	-	Тусгаг-даагүй	Тусгаг-даагүй	Үгүй
8	Байгалийн түүхийн музейг шинээр барих	100.0	-	18.0	7.3	Тийм /төсөвт өртөг нь 94.5 тэрбум төгрөг, санхүүжих хугацаа нь 2020-2022 он болсон/
9	Үндэсний урлагийн Их театр шинээр байгуулах	100.0	-	0.5	0.5	Тийм /төсөвт өртөг 152.5 тэрбум төгрөг болж нэмэгдсэн/
10	Байгалийн түүхийн музейн барилгыг буулгаж, их хаадын музейн барилга барих	30.0	-	48.8	10.99	Тийм /төсөвт өртөг 53.6 тэрбум төгрөг болсон/
11	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто зам	48.0	Тусгаг-даагүй	19.0	11.0	Тийм /төсөвт өртөг өөрчлөгдөөгүй, санхүүжих хугацаа 2019-2021 он болсон/
12	Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн хатуу хучилттай 50 км авто зам	49.4	5.0	15.0	9.9	Тийм /төсөвт өртөг өөрчлөгдөөгүй, санхүүжих хугацаа 2019-2021 он болсон/

13	Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их Тамир чиглэлийн гүүр, 63 км авто замын ажил	69.0	5.0	12.0	9.0	Тийм /төсөвт өртөг өөрчлөгдөөгүй, санхүүжих хугацаа 2019-2021 он болсон/
14	Улсын чанартай авто зам, гүүрний засвар, арчлалт / улсын хэмжээнд/	30.0	30.0	-	-	Үгүй
15	Гаалийн ерөнхий газар, газар, хоорондын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж	32.2	26.9	15.9	0.5	Тийм /төсөвт өртөг 114.1 тэрбум төгрөг, санхүүжих хугацаа 2019-2021 он болсон/
16	Гаалийн шинэчлэл - Гаалийн хороо, гаалийн төв болон газар хоорондын лабораторийн барилга / улсын хэмжээнд 8 байршил/	32.3	14.4	3.9	1.1	Тийм /төсөвт өртөг 38.3 тэрбум төгрөг, санхүүжих хугацаа 2019-2021 он болсон/
17	Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах эрчим хүчний дамжуулах, түгээх шугам сүлжээ	46.96	46.96	-	-	Үгүй
18	“Чойр” дэд станцын өргөтгөл, шинэчлэлт / Концессын эргэн төлөлт/	83.7	37.2	30.5	14.1	Тийм /төсөвт өртөг 90.3 тэрбум төгрөг, санхүүжих хугацаа 2019-2022 он болсон/
			7.0	2.5		
19	Оюутолгой-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт ЦДАШ, дэд станц / Концессын эргэн төлөлт/	84.8	Төсөвт өртөг нь 79.3 тэрбум төгрөг гэж тусгагдсан	Төсөвт өртөг нь 85.6 тэрбум төгрөг гэж тусгагдсан	Тусгагдаагүй	Тийм /төсөвт өртөг нь 91.4 тэрбум төгрөг болсон. Санхүүжих хугацаа 2020-2022 он болсон/

Эх сурвалж: Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотгол

Нийт 19 төслөөс 10 нь дараагийн буюу 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт шилжин тусгагдсан бол 7 нь хэрэгжиж дууссан байна. Харин 2 төсөл, арга хэмжээ буюу сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр шинээр тусгагджээ. 10 төсөл, арга хэмжээний зургаагийнх нь төсөвт өртөг нэмэгдсэн байна. Угтаа бол анх дээрх 19 төсөл, арга хэмжээ бүгд 2018-2021 онд хэрэгжиж дуусах буюу санхүүжилтээс шилжих дүн байхгүй байсан ч бодит байдал дээр тэдгээрийн 52.6 хувь нь дараагийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт шилжжээ. Инженерийн рот гэсэн төслийг эс тооцвол бусад төсөл, арга хэмжээ хэдийгээр санхүүжилтийн дүн нь

заримдаа ялгаатай ч тухайн жилийн улсын төсөвт тусгагдаж байсан нь сайн хэрэг юм.

Улсын төсвийн санхүүжилттэй төсөл, арга хэмжээ 2018-2021, 2021-2025 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдэд ямар байдалтай тусгагдсаныг доорх хүснэгтэд харьцуулав.

Хүснэгт 13. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан улсын төсвийн санхүүжилттэй төсөл, арга хэмжээний тоо

№	Үзүүлэлт	2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтэд эх үүсвэрийн эзлэх хувь	2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтэд эх үүсвэрийн эзлэх хувь
1	Улсын төсвийн санхүүжилттэй төслийн тоо. Үүнээс:	18 ⁸	3.71%	29	6.3%
	Шилжих	6	2.40%	-	-
	Шинэ	12	1.31%	-	-
2	Холимог эх үүсвэртэй /гадаад зээл тусламж, улсын төсөв ба гадаад зээл, тусламж, Хөгжлийн банк/ төслийн тоо. Үүнээс:	20	13.98%	19	14.9%
	Шилжих	19	13.72%	-	-
	Шинэ (эх үүсвэр амлагдсан)	1	0.26%	-	-

Эх сурвалж: 2018-2021, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээг авч үзэхэд 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс 2021-2025 оны хөтөлбөрт шилжин тусгагдсан байх учиртай дараах төсөл, арга хэмжээ байсан. Үүнд:

1. Дуурь, бүжгийн эрдмийн театрын барилга (2020-2022 он)
2. Улсын драмын эрдмийн театрын барилга (2020-2022 он)
3. Төв номын сангийн барилга (2020-2021 он)
4. Шинжлэх ухаан, инновацын төвийн кластер (2020-2023 он)
5. Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн (2020-2021 он)
6. Чингис хот-Дадал сум чиглэлийн хатуу хучилттай автозамын үргэлжлэл, 50 км (2020-2022 он)
7. Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/ (2020-2021 он)
8. Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/ (2020-2022 он)

8 Хөтөлбөрт 18 төсөл гэж бичигдсэн ч жагсаалтыг шалгахад нийт 19 төсөл байсан.

9. Нэг иргэн-Нэг бүртгэл хөтөлбөр (2020-2025 он)

10. Хил хамгаалах байгууллагын авто парк шинэчлэл (2020-2025 он)

11. Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай автозам (2019-2021 он)

Өөрөөр хэлбэл дээрх төсөл, арга хэмжээнүүд нь 2018-2021 онд эхэлсэн төсөл, арга хэмжээнүүд байсан. Гэвч 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг шалгахад дээрх 11 төсөл, арга хэмжээ байгаагүй буюу 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй хэр нь дараагийн буюу 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт өмнөх хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдан хэрэгжиж байсан мэтээр тусжээ. Эдгээр нь улсын төсвийн хөрөнгөөр санхүүжиж байсан төсөл, арга хэмжээ байгаагаас үзвэл хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн уялдаа сул байна.

6. Кейс судалгаа: Хэрэгжилт нь удааширсан төсөл, арга хэмжээнүүд

2023 оны төсвийн тухай хуульд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийг нягтлахад анх төсөвт тусгагдсанаасаа хойш 10 ба түүнээс дээш жил үргэлжилж буй дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Үүнд:

Хүснэгт 14. Хэрэгжилт нь ноцтой удааширсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжууд

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он
1	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /УБ, НД/	2010	2023
2	“Хан Хэнтий” чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2011	2023
3	Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан, Улиастай сум/	2011	2023
4	“Төв халх” дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/	2011	2024
5	Үндэсний номын сангийн барилга /УБ, СБД/	2012	2023
6	Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум/	2012	2023
7	Хөдөө аж ахуйн их сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/	2013	2023
8	Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах /Архангай, Эрдэнэбулган сум/	2013	2023
9	Сургуулийн барилга, 220 суудал /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	2014	2023
10	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø800-ийн гол шугамыг Ø1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/ /УБ, СХД/	2014	2024
11	Усан спорт цогцолбор /Улаанбаатар, СХД, “Найрамдал” зуслан/	2014	2024
12	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /УБ, БГД/	2014	2023
13	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто замын дуусгал /Завхан/	2015	2023
14	Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга төслийн Монголын талын хөрөнгө /УБ, БЗД/	2015	2023
15	FM-104.5 радиогийн хажуугийн 250 метр замыг асфальтан зам болгох, Сансарын колонкийн арын төв зам хүртэлх /УБ, БЗД/	2016	2023
16	Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто замын техник эдийн засгийн үндэслэл болон инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын үлдэгдэл санхүүжилт	2017	2023

Эх сурвалж: Монгол Улсын 2021, 2022, 2023 оны төсвийн тухай хууль

Дээрх хүснэгтээс үзэхэд дийлэнхдээ боловсрол, шинжлэх ухаан, соёл, нийтийн биеийн тамир спортын салбарын төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт анхаарал татахуйцаар удааширсан байна. Тодруулбал, нийт 16 төсөл, арга хэмжээний 4 нь БШУС, 4 нь Соёлын сайд, 3 нь Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргад тус тус хамааралтай байгаа юм. Эдгээр төсөл, арга хэмжээнээс энэхүү судалгааны хүрээнд дараах төсөл, арга хэмжээг сонгож хэрэгжилт удааширсны шалтгааныг дэлгэрүүлэн судаллаа.

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилга

Уг барилга байгууламж нь анх 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах төсөл, арга хэмжээний жагсаалтад БШУС-ын багцад тусгагдсан. Тухайн үед төсөвт өртөг нь 3.2 тэрбум төгрөг ба 2013 онд дуусахаар төлөвлөгджээ. Гэвч энэхүү төсөл 2023 онд төсвийн тухай хуульд дахин тусгагдсан бөгөөд 2012-2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад нийтдээ 9 жил тусгагдсан байна.

Хүснэгт 15. Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 960 хүүхдийн суудалтай сургуулийн төсөвт өртгийн өөрчлөлт, 2012-2023 он

Төсвийн жил	Төсөвт өртөг, сая төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Дуусах хугацаа (он)
2012	3,200.0	525.0	2013
2013	3,200.0	600.0	2014
2014	2,906.8	1,153.4	2015
2015	4,693.5	669.1	2016
2016	5,654.3	1,200.0	2017
2017	5,654.3	800.9	2018
2018	5,274.0	1,000.0	2019
2019	5,274.0	651.7	2020
2020	-	Тусгагдаагүй	
2021	-	Тусгагдаагүй	
2022	-	Тусгагдаагүй	
2023	5,444.2	496.0	2023

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2023 оны төсвийн тухай хууль

Уг төслийн эхний санхүүжилт нийт төсөвт өртгийн 16.4 хувьтай тэнцэж байна.

Тус барилгын төсөвт өртөг анх 2012 онд 3.2 тэрбум төгрөг байсан бол 2023 оны төсөвт энэ дүн 5.4 тэрбум төгрөг болжээ. БШУЯ-ны тайлбарласнаар зураг төсөл буруу хийгдсэнтэй холбоотойгоор барилгын ажлыг дуусгаж чадалгүй олон жил болсны уршгаар төсөвт өртөг нь 1.7 дахин нэмэгдсэн байна. Энэ нь барилгын ажил удааширсны улмаас эхний шатны хөрөнгө оруулалтын үнэ цэн алдагдаж, үүссэн элэгдлийг нөхөхүйцээр дахин хөрөнгө оруулах шаардлагатай болсонтой холбоотой байж болох юм.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга” төслийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/

Энэхүү барилга байгууламж нь анх 2015 онд эхэлсэн ч Монголын талын хөрөнгө нь 2018, 2022, 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад БШУС-ын багцад дараах байдлаар тусгагдсан байна.


Хүснэгт 16. “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга” төслийн Монголын талын хөрөнгө, 2018-2023 он

Төсвийн жил	Төсөвт өртөг, сая төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Дуусах хугацаа
2018	12,900.0	5,000.0	2015-2020
2019	-	Тусгагдаагүй	
2020	-	Тусгагдаагүй	
2021	-	Тусгагдаагүй	
2022	12,900.0	2,104.6	2015-2023
2023	11,575.7	3,381.5	2015-2023

Эх сурвалж: Монгол Улсын 2018-2023 оны төсвийн тухай хууль


Тус барилга байгууламжийн Монголын талын гаргах хөрөнгө 2018 онд 12.9 тэрбум төгрөг байсан (төсөл хэдийгээр 2015 онд эхэлсэн ч 2015, 2016, 2017 оны төсвийн хуулиудад тусгагдаагүй) бол 2023 онд 11.6 тэрбум төгрөг болж тусгагджээ. Учир нь Монголын талын хөрөнгөөр баригдах хэсгийн бүтээн байгуулалтын тендерийг 2018 онд зарлаж “Энх-Орчлон” ХХК 11.576 тэрбум төгрөг санал болгосноор төсөвт өртөг 12.9 тэрбум төгрөгөөс 11.576 тэрбум төгрөг болж буурсан байна.⁹ Буцалтгүй тусламжийн хүрээнд барих эмнэлгийн барилгын ажил удааширч байсан тул дахин төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулан амбулаторийн хэсгийг эхлээд ашиглалтад оруулахаар болсон ажээ. Японы тал гэрээний үүргээ биелүүлж, буцалтгүй тусламжийн хөрөнгөөрөө тус барилгыг барьж 2019 оны 6 дугаар сард ашиглалтад оруулсан. Барилгын ажил удааширсантай холбогдуулан Монголын талын хөрөнгө ч саатсан тухай ЖАЙКА-гийн тайланд дурджээ.¹⁰

Зураг 8. “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга” төслийн явцын зураглал



9 <https://www.tender.gov.mn/mn/result/detail/1528882764953>

10 <https://openjicareport.jica.go.jp/pdf/12346615.pdf>



Үндэсний номын сангийн барилга



Тус барилга 2014 оны төсвийн тухай хуульд 2012 онд эхэлсэн мэтээр тусгагдсан ч 2012 болон 2013 оны төсвийн тухай хуульд уг төсөл, арга хэмжээ огт тусгагдаагүй. Соёлын яамны тайлбарласнаар барилгын ажил нь 2014 онд эхэлсэн ч газрын маргаан, санхүүжилтийн улмаас барилгын ажил удааширсан. 2017 оноос барилгын гүйцэтгэлийн ажил эрчимжсэн ч “Ковид-19” цар тахал, гүйцэтгэгч компанийн гүйцэтгэх захирал нас барсантай холбоотойгоор ажил дахин хэсэг хугацаанд

зогссон бөгөөд энэ хугацаанд барилгын төсөвт өртөг үндсэндээ 2 дахин нэмэгджээ. Уг төслийн 2014 онд батлагдсан эхний санхүүжилт нийт төсөвт өртгийн 18.3 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 17. Үндэсний номын сангийн барилгын төсөвт өртгийн өөрчлөлт, 2012-2023 он

Төсвийн жил	Төсөвт өртөг, сая төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Дуусах хугацаа
2012	-	Тусгагдаагүй	-
2013	-	Тусгагдаагүй	-
2014	12,000.0	2,200.0	2012-2015
2015	12,000.0	1,000.0	2012-2016
2016	12,000.0	1,000.0	2012-2017
2017	12,000.0	340.0	2012-2018
2018	12,000.0	1,000.0	2012-2019
2019	12,000.0	3,355.0	2012-2020
2020	18,900.0	10,255.0	2012-2020


Төсвийн жил	Төсөвт өртөг, сая төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Дуусах хугацаа
2021	-	Тусгагдаагүй	-
2022	19,900.0	2,081.8	2012-2022
2023	23,767.2	3,867.2	2012-2023

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2023 оны төсвийн тухай хууль

Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудсанд байршуулсан мэдээллээс үзэхэд хуучнаар Соёл, спорт, аялал жуулчлалын яам “Акми Холдинг” ХХК-тай 2014 оны 8 дугаар сарын 21-ний өдөр 3/206 тоот барилга угсралтын 11,999.8 сая төгрөгийн үнэтэй гэрээг байгуулж ажил эхэлсэн ч өнөө хэр барилгын ажил дуусаагүй бөгөөд энэ хугацаанд гэрээг нийт 5 удаа сунгасан гэж Соёлын яам тайлбарласан. Барилгын материалын үнэ, ажиллах хүчний цалин хөлсний өсөлтөөс шалтгаалж барилгын төсөвт өртөг нэмэгдэх байдал үүссэн тул тухайн үед Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам тус компанитай 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 6,900.2 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулснаар гэрээний дүн 18,900 сая төгрөг болсон. Гэвч барилгын тоо, хэмжээ гадна фасадын металл өнгөлгөөний талбайгаар тооцогдож, төсөвт өртөг дахин 794.8 сая төгрөгөөр нэмэгдэх болжээ. Тиймээс нэмэлт гэрээ байгуулж, гэрээний хугацааг сунгах шийдвэр 2022 оны 2 дугаар сарын 17-ны өдөр гарсан гэсэн мэдээллийг Соёлын яам өгсөн. Гэвч гүйцэтгэгч компани нэмэлт гэрээний гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх боломжгүй байжээ. Энэ нь тус компанийн гүйцэтгэх захирал таалал төгсөж, компанийг өв залгамжлах удирдлагын асуудал тодорхойгүй болсноос хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж, санхүүгийн хүнд байдалд орсонтой холбоотой байсан ажээ. Улмаар Соёлын яам 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 3/2479 тоот албан бичгээр “Акми Холдинг” ХХК-д гэрээ цуцлах тухай мэдэгдлийг хүргүүлж, гэрээг цуцалжээ. 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр дахин тендер зарлаж 5,948.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй үлдсэн ажил болон гадна фасад гүйцээх, дотор засал, хаалга цонх гэх зэргийг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж авсан байна.¹¹

11 <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1679449909197>

Зураг 9. Үндэсний номын сангийн барилгын төслийн явцын зураглал



Эндээс жил бүрийн төсвийн тухай хуулийг батлахдаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, дуусах боломжтой хугацаа зэргийг нарийвчлан нягталж, бодит байдлыг үнэлэхгүй, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дуусах бодитой цаг хугацааг төлөвлөдөггүй нь харагдаж байна. Тухайлбал, 2014 онд 12 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлыг санхүүжүүлэх дүнг ердөө 2.2 тэрбум төгрөгөөр тусгачхаад 2015 онд дуусна гэж төлөвлөх нь үндэслэлгүй хэрэг юм. Энэ алдаа харамсалтай нь төсвийн төлөвлөлтөд жил бүр давтагдаж, төсвийн хөрөнгийг хэрхэн үрэлгэн, үр дүн муутай зарцуулж байгаагийн тод жишээ болсоор байна. Ингэж барилгын ажил олон жил үргэлжлэхээр үнийн өсөлтийн улмаас анхны төсөвт өртөг хүрэлцээгүй болох нь зүйн хэрэг юм.

“Төв халх” дуулалт жүжгийн театрын барилга

2012 онд Дундговь аймагт баригдаж эхэлсэн “Төв халх” дуулалт жүжгийн театрын барилга нь эхний 2 жилийг эс тооцвол 2013-2018 онд улсын төсөвт тусгагдаагүйн улмаас санхүүжилтгүй болж, олон жил “царцсан” тул барилгын ажлын эхэн үед хийгдсэн барилгын суурь, шалны бетон арматур зэрэг нь элэгдэж, улмаар дахин хийх шаардлагатай болсон тухай Соёлын яамны эх сурвалж мэдээлсэн. Энэ нь олон жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэх шалтгаануудын нэг мөн бөгөөд төсвийн хөрөнгийг үрэлгэн, үр дүн муутай зарцуулж байгаагийн бас нэг жишээ юм. Төсөвт өртөг нь 2021 онд 4 тэрбум орчим төгрөгөөр нэмэгдсэн уг театрын барилга ажлыг 2024 онд дуусгахаар 2023 оны төсөвт тусгажээ.

Хүснэгт 18. “Төв халх” дуулалт жүжгийн театрын төсөвт өртгийн өөрчлөлт, 2011-2023 он

Төсвийн жил	Төсөвт өртөг, сая. төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Дуусах хугацаа
2011	6,800.0	440.0	2011-2013
2012	6,800.0	3,300.0	2011-2014
2013	-	Тусгагдаагүй	-
2014	-	Тусгагдаагүй	-
2015	-	Тусгагдаагүй	-
2016	-	Тусгагдаагүй	-
2017	-	Тусгагдаагүй	-
2018	-	Тусгагдаагүй	-
2019	6,800.0	2,000.0	2011-2020
2020	6,800.0	50.0	2011-2021
2021	10,543.7	1,710.0	2011-2022
2022	10,543.7	200.0	2011-2023
2023	10,543.7	671.7	2011-2024

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2023 оны төсвийн тухай хууль

Энэ төслийн эхний санхүүжилтэд төсөвт өртгийн ердөө 6.5 хувьтай тэнцэх л хөрөнгийг тусгаж байжээ. Төслийн санхүүжилт 2013-2018 оны төсөвт тусгагдаагүй бөгөөд 2019 оны төсөвт 2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн.

Завхан аймгийн хөгжимт жүжгийн театрын барилга

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын барилга 2011 онд 1987 онд батлагдсан театрын барилгын зургаар эхэлж, 2011-2012 онд барилгын суурь хэсгийн ажлыг гүйцэтгэсэн боловч 2013-2017 онд санхүүжилтгүйн улмаас “царцаж”, гүйцэтгэгч компани ч ажлаа орхижээ. 2017 онд Завхан аймгийн орон нутгийн өмчийн газраас ахин тендер зарлаж¹² “LCB” ХХК шалгаран 2018 оноос барилгын ажил дахин эхэлсэн юм байна. Өнгөрсөн хугацаанд барилгын гадна фасад, дээвэр, цонх, агааржуулалтын систем зэрэг ажлууд хийгдсэн. Гэвч батлагдсан төсөвт барилгын дотоод засал, тайзны интерьер, үзэгчдийн суудал гэх зэрэг ажлуудын санхүүжилт тусгагдаагүй, барилгын материалын үнэ, ажлын хөлс нэмэгдсэн зэрэг шалтгаанаар нэмэлтээр 4.2 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай болсон тул төсөвт өртөг 2020 онд огцом нэмэгджээ. Улмаар “Ковид-19” цар тахлын улмаас барилгын ажил мөн удааширсаар 2012 онд дуусна гэж төлөвлөсөн барилга 2023 онд буюу 13 жилийн дараа л дууссан. Энэ хугацаанд барилгын ажлын анхны төсөвт өртөг 4 дахин нэмэгдсэн тухай Соёлын яамны эх сурвалж мэдээлсэн.

12 <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1491498893988>


Хүснэгт 19. Завхан аймгийн хөгжимт жүжгийн театрын төсөвт өртгийн өөрчлөлт, 2011-2023 он

Төсвийн жил	Төсөвт өртөг, сая төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Дуусах хугацаа
2011	3,000.0	150.0	2011-2012
2012	3,000.0	1,200.0	2011-2014
2013	3,000.0	3,000.0	2011-2013
2014	3,000.0	636.3	2011-2014
2015	-	Тусгагдаагүй	-
2016	9,960.0	300.0	2011-2017
2017	-	Тусгагдаагүй	-
2018	9,960.0	3,000.0	2011-2019
2019	9,960.0	4,118.3	2011-2019
2020	13,492.0	1,500.0	2011-2021
2021	13,492.0	2,032.0	2011-2021
2022	13,492.0	1,633.5	2011-2022
2023	14,005.2	513.2	2011-2023

Эх сурвалж: Монгол Улсын 2011-2023 оны төсвийн тухай хууль

Энэ төслийн эхний санхүүжилтэд төсөвт өртгийн зөвхөн 5 хувьтай тэнцэх л хөрөнгийг тусгаж байжээ.

Зураг 10. Завхан аймгийн хөгжимт жүжгийн театрын төслийн явцын зураглал



Энэ жишээ мөн л олон жил үргэлжилж буй барилгын ажлын төсөвт өртөг хэрхэн үлэмж нэмэгдэж, зарим жил шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт тусгаагүйн

улмаас эхэлж оруулсан хөрөнгийн үнэ цэн алдагдаж байгаагийн тод жишээ юм. Тиймээс төсөл, арга хэмжээний үргэлжлэх хугацааг бодитой төлөвлөх, шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт тогтмол тусгах зэргээр эхлүүлсэн төсөл, арга хэмжээг аль болох түргэн дуусгах шаардлагатай байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 2021 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланд дурдсанаар “Ковид-19” цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улс гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, тоног төхөөрөмжүүдийн тээвэрлэлтийн явцад зарим орнууд хилээ хаасан, БНХАУ-ын Эрээн хилийн боомтоор Монгол Улс руу орох ачаа тээвэрлэлтийг хязгаарласан, ОХУ-ын Хиагт-Монгол Улсын Алтанбулаг боомт хаагдаж автозамын ачаа тээвэр зогссон зэрэг нөхцөл байдалтай холбоотой төслүүдийн хэрэгжилт удааширсан бөгөөд Эрээн болон Замын-Үүд боомтын ачаа тээврийн саатлаас үүдэлтэйгээр барилгын материалын үнэ огцом өсөж, нийлүүлэлт багассан нь төсөвт өртөг нэмэгдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл байжээ. Гэхдээ төсөл, арга хэмжээ бүрийн төсөвт өртөг харилцан адилгүй өсөлттэй байгаа нь үнийн өсөлтөөс гадна өөр бусад хүчин зүйлс төсөвт өртгийн өөрчлөлтөд нөлөөтэй байна гэдгийг тодорхой илтгэж байгаа юм.

7. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын олон улсын туршлага

Улс орон бүрийн хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг тодорхойлж, хэмжиж байгаа арга нь өөр байдаг. Ерөнхийдөө энэ нь нэг жилээс илүү хугацаанд хэрэглэх зам, Засгийн газрын барилга байшин гэх мэт биет дэд бүтэц, инновац, судалгаа хөгжлийг дэмжих зөөлөн дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтыг хэлдэг.¹³ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын судалгаагаар тус байгууллагын гишүүн орнуудын хувьд 2009 оноос хойш төв Засгийн газрын болон орон нутгийн түвшинд улсын төсвийн хөрөнгө оруулалт тасралтгүй буурсан байдаг бол манай улсын хувьд жил бүр харилцан адилгүй хэдий ч өсөх хандлагатай байгаа юм.¹⁴

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт төгс байхын тулд төсвийн төлөвлөлтөөс эхлээд үнэлгээ, сонголт, төсөвлөлт, хэрэгжилт, хэрэгжсэний дараах хяналт гэсэн бүтэн циклийг агуулж байх ёстой гэж үздэг. Тухайлбал, **төлөвлөлтийн** үүднээс хөрөнгө оруулалтын төсөл нь урт хугацааны, иж бүрэн стратегид суурилсан, зардлын найдвартай тооцоо, одоо байгаа хөрөнгийн нөөц, хэрэгцээ зэрэгт үндэслэсэн байх ёстой. Казахстан улсын Төсвийн хуулийн 2 бүлэг¹⁵ нь төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой байдаг. Тус хуулийн 30 дугаар бүлэг хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвлөлтийн талаар заалтуудыг агуулдаг бол 31 дүгээр бүлэгт төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой заалтууд бий. 30 дугаар бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын 3 алхмыг заасны нэг нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санал боловсруулах үйл явц юм. Тодруулбал, хөрөнгө оруулалтын төслийн саналууд нь дунд хугацааны стратегитай уялдах ёстой бөгөөд нягт нямбай нягтлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийг төсөвт тусгахаас өмнө хууль тогтоох байгууллагын холбогдох төсвийн хороодоос зөвшөөрөл авах ёстой байдаг ажээ. Гэтэл Чили улсын хувьд яамд нь өөрийн хэрэгцээнд тулгуурлан хөрөнгө оруулалтаа төлөвлөдөг байна.¹⁶ Төрийн хэргийн яам нь жил бүр хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулж тухайн жилд хэрэгжүүлэх төслийн жагсаалтуудыг бэлтгэхийн хажуугаар дараагийн 3 жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг мөн нэгтгэдэг. Европын холбоо (ЕХ)-ны олон улс үндэсний болон салбарын урт хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй байдаг бөгөөд боловсруулах үйл явцад нь орон нутгийн удирдлага, иргэд зэргийг оролцуулсан олон нийтийн хэлэлцүүлэг ихээхэн чухал байр суурь эзэлдэг ажээ.¹⁷

Хөрөнгө оруулалтын төслийн **үнэлгээ, сонголтын** хувьд стандарт болон төрийн процедурт суурилсан байх ёстой бөгөөд хараат бус байгууллагуудын саналыг авсан байх зарчим үйлчилж байна. Мөн үнэлгээ, сонголт, хараат бус үнэлгээний үр дүнг олон нийтэд ил тод болгох нь дутуугүй чухал юм. ЕХ-ны орнуудад үнэлгээ,

13 Effective public investment across levels of Government, Implementing the OECD principles, OECD, 2019.

14 Effective public investment across levels of Government, Implementing the OECD principles, OECD, 2019, <https://publicinvestment.gov.mn/>

15 https://track.unodc.org/uploads/documents/BRI-legal-resources/Kazakhstan/11_-_Budget_Code_EN.pdf

16 <https://observatorioplanificacion.cepal.org/en/planning-systems/national-public-investment-system-chile>

17 https://economy-finance.ec.europa.eu/system/files/2022-10/dp154_en.pdf

сонголт нь ихэвчлэн стандарт, дүрэм журамд үндэслэдэг бөгөөд хараат бус үнэлгээ түгээмэл хийгддэггүй байна. Харин Казахстан улсын хувьд Төсвийн тухай хуульд нь зааснаар төслийн үнэлгээ хийх, төслийг сонгох үндсэн 3 шат байдаг ажээ. Эхний шатанд төслийн зардал-үр ашгийн шинжилгээ хийж, эдийн засгийн үндэслэлийг нь гаргасан дэлгэрэнгүй тайлан бэлтгэдэг. Улмаар 2 дахь шатанд тус шинжилгээний үр дүнг хараат бус хяналтаар үнэлүүлж баталгаажуулна. Энэ тохиолдолд л зөвхөн Сангийн яам төслийн шинжилгээг хүлээн зөвшөөрдөг юм байна. Үүний дараа жилийн төсвийн процессоор дамжуулан төслийг сонгодог ажээ. Зөвхөн ТЭЗҮ-ийн бүрэн тайлантай, хөндлөнгийн эерэг баталгаажуулалттай, холбогдох төсвийн хорооны дэмжсэн шийдвэртэй төслүүдийг төсвийн төсөлд тусгана гэж холбогдох хуульд нь заасан байдаг. Азийн тэргүүлэгч орнуудын нэг болох БНСУ-д төслийн бүрэн хэмжээний үнэлгээ хийхээс өмнө хөндлөнгийн шинжилгээ хийлгэдэг бөгөөд томоохон төслүүдийн урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулж, үнэлгээг үргэлжлүүлэх эсэхээ шийддэг юм байна.¹⁸ Ингэхдээ салбараас болон төслийн үнийн дүнгээс хамаарч босго дүнтэй байдаг. Тухайлбал барилга, мэдээлэл, харилцааны технологи, судалгаа, хөгжлийн салбарын төслүүд, нийт төсөвт өртөг нь 50 тэрбум воноос их, тэр дундаа улсын төсвөөс санхүүжүүлэх дүн нь 30 тэрбум воноос их төслүүд болон нийгмийн сайн сайхан, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, соёл, аялал жуулчлал зэрэг салбарт хийгдэх 50 тэрбум воноос их төсөвт өртөгтэй бүх төсөл ТЭЗҮ хийлгэх ёстой юм байна. Чили улсын Нийгмийн хөгжил, гэр бүлийн яам нь Хөрөнгө оруулалтын нийгмийн үнэлгээний хэлтсээрээ дамжуулан улсын төсөвт тусгагдах төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн нийгмийн үнэлгээг хийдэг. Тус үнэлгээг хийхэд бүх сонирхсон байгууллага оролцох боломжтой байдаг нь бусад талуудын оролцоог хангаж буй хэлбэр гэж үзэж болох юм.

Хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд дараагийн чухал цикл болох **төсөвлөлтийг** хийхдээ дунд хугацааны төсвийн хүрээнд багтаан хийх ба ингэснээр стратегийн төлөвлөгөө, жилийн төсвийн шийдвэр, урт хугацааны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хоорондын уялдааг хангах боломжтой болдог гэж үздэг. Харин төслийн **хэрэгжилтийг** амжилттай байлгахын тулд тухайн төсөл, арга хэмжээ хэрэгжих нийт хугацаанд шаардлагатай санхүүжилтийг бүрэн төсөвлөх хэрэгтэй. БНСУ, Чили, Ирланд, Их Британи зэрэг орнууд улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслүүдийг сайн хэрэгжүүлдэг туршлагатай. Эдгээр орны Сангийн яам болон салбарын яам хамтран төслийн хэрэгжилтийг санхүүгийн болон санхүүгийн бус талаас нь тогтмол хянадаг байна. Мөн төслийн бодит өртөг тодорхой хэмжээнээс илүү гарсан тохиолдолд төсөвт өртгийг дахин үнэлдэг ажээ. Тухайлбал, БНСУ-ын хувьд бодит өртөг 20 хувиар өссөн тохиолдолд, харин Чили улс 10 хувиар өссөн тохиолдолд төсөвт өртгийг дахин тооцдог.

Томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийн **хэрэгжилтийн дараах үнэлгээ** нь ирээдүйн бодлого боловсруулахад чухал нөлөө үзүүлдэг. Тухайлбал Ирланд улс бүх томоохон хөрөнгө оруулалтын төсөл (20 сая еврогоос дээш төсөвт өртөгтэй) болон төсөвт өртөг багатай бусад төслүүдийн ядаж 5 хувь нь төсөл, арга хэмжээний эхэнд тооцож байсан үр өгөөж төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээр бий болсон эсэхийг шалгахын тулд төслийн хэрэгжилтийн дараах үнэлгээг хийдэг байна.¹⁹

18 https://economy-finance.ec.europa.eu/system/files/2022-10/dp154_en.pdf

19 https://economy-finance.ec.europa.eu/system/files/2022-10/dp154_en.pdf

8. Дүгнэлт, зөвлөмж

Энэхүү судалгааны хүрээнд 2017, 2019, 2021, 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдлыг судаллаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг, санхүүжилтийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа ч хэрэгжилт нь удааширч, он дамжин шилжих тохиолдол их байна. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт хугацаандаа дуусахгүй байхад тухайн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч хугацаандаа ажлаа дуусгаагүй, санхүүжилт хугацаандаа олгогдоогүй зэрэг шалтгаанууд түгээмэл байсан хэдий ч анхнаасаа төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг буруу хийсэн, зураг төсөл, газрын зөвшөөрөл нь шийдэгдээгүй төсөл, арга хэмжээг улсын хөрөнгө оруулалтын төсөвт тусган баталсан зэрэг нь тухайн арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй он дамжин шилжих бас нэгэн шалтгаан болсоор байна. Өөрөөр хэлбэл Төсвийн тухай хууль болон “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын холбогдох заалтуудыг зөрчиж, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулан баталсаар байна гэсэн үг юм.

Түүнчлэн хугацаандаа хэрэгжилгүй он дамжиж буй шилжих төсөл, арга хэмжээ нь шилжихдээ анх батлагдсан хугацааг өөрчлөн шинэ төсөл, арга хэмжээ мэтээр тусгах зэрэг зөрчлүүд ч улсын хөрөнгө оруулалтын төслүүдэд цөөнгүй байгаа нь 2017, 2019, 2021, 2022 оны улсын батлагдсан төсвөөс ажиглагдлаа. Төсвийн тухай хууль, төсвийн хөрөнгө оруулалтын холбогдох журамд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тавигдах шаардлагуудыг тодорхой тусгасан байдаг. Эдгээр шаардлагын нэг нь төсөвт зураг төсөвтэй төслийг тусгах явдал юм. Гэсэн хэдий ч төсөл, арга хэмжээний батлагдсан жагсаалт, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем зэрэг нийтэд ил тод байдаг мэдээллийн эх сурвалжаас шалгахад төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэхдээ буюу тендерийг зарлахдаа тухайн төслийн зураг төслийг боловсруулах ажлын даалгаврыг хавсаргаж буй тохиолдлууд түгээмэл байсан бөгөөд зураг төсөл нь бэлэн болоогүй, шаардлагатай судалгаа, төлөвлөлт нь хийгдээгүй батлагдсан эдгээр төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй, он дамжин шилжих нь ойлгомжтой юм. Мөн хэрэгжүүлэх арга хэмжээ, төсвийн зарцуулалт тодорхой бус олон тооны арга хэмжээг багцлан нэг ерөнхий утгаар тусгасан, төслийн хүчин чадал, байршлыг заагаагүй зэрэг зөрчилтэй төсөл, арга хэмжээ олноороо улсын төсөвт тусгагдсаар байгаа бөгөөд эдгээр зөрчлөөс шалтгаалан тухайн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанарыг хэрхэн үнэлэх, төсвийн зарцуулалтад хэрхэн хяналт тавих зэрэг нь тодорхой бус байна.

Өндөр төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн тухайн төсвийн жилд санхүүжих дүнг маш багаар тогтоосноор тухайн төсөл, арга хэмжээ санхүүжилтийн дутагдлаас шалтгаалан хэрэгжихгүй байх, тухайн төсөл, арга хэмжээг бүрэн санхүүжүүлж дуусах хүртэл хэрэгжилтийн хугацаа хойшлогдон шилжих төслүүдийн тоо нэмэгдэж байгаа юм. Түүнчлэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зарим төсвийн жилд орхигдуулснаар төсөл, арга хэмжээний гүйцэтгэл саатаж, эхлээд оруулсан хөрөнгийн үнэ цэн алдагдаж, дахиж эхлэхээс өөр аргагүй

болж байсан тохиолдлууд ч байна. Энэ нь нөгөөтээгүүр төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэж, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах үндсэн шалтгаан болдог. Тиймээс төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хангалттай төсөвлөж, хуульд заасан хугацаанд дуусгах хэрэгтэй байна.

Олон тооны төсөл, арга хэмжээ хугацаандаа дуусалгүй, хэдэн арван жил дамнан үргэлжилсээр байхад тэдгээр төсөл, арга хэмжээг дуусгахын тулд санхүүжилтийг нь гүйцээж батлахад анхаарахын оронд шилжих төсөл, арга хэмжээний тооноос дутуугүй, зарим тохиолдолд давж гарсан тооны шинэ төсөл, арга хэмжээ, барилга байгууламж улсын төсвийн хөрөнгөөр барьж, байгуулахаар баталж байгаа нь хөрөнгө оруулалтын төсөвлөлт төлөвлөлтийн шатнаасаа эхлэн зохисгүй байгааг илтгэж байгаа юм.

2018-2021, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтөөс харахад улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон тухайн төсвийн жилд улсын төсвөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хооронд уялдаа холбоо сул байгаа нь ажиглагдлаа.

Судалгааны үр дүнд суурилсан дээрх дүгнэлтүүдэд үндэслэн дараах зөвлөмжийг хууль тогтоогч нар болон Засгийн газарт хүргүүлж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль болон “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хэлбэрэлтгүй мөрдүүлэх;
- Эх үүсвэр үл хамааран улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээг жилийн төсвийн төсөлд тусгахгүй байх;
- Гурваас илүү жил шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ, барилга байгууламж ирэх жилийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөж буй жагсаалтын 50-иас илүү хувийг эзлэхээр байвал батлагдах жагсаалтад шинэ төсөл, арга хэмжээ, барилга байгууламж тусгадаггүй байх зохицуулалтыг Төсвийн тухай хуульд тусгах;
- Хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ажлаа цаг хугацаандаа дуусгаж чадаагүй гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулах, хар жагсаалтыг олон нийтэд ил тод мэдээлэх, тухайн гүйцэтгэгчээр дахин ажил гүйцэтгүүлэхгүй байх, үлдсэн ажлыг өөрийнх нь хөрөнгөөр дуусгуулдаг зохицуулалтыг Төсвийн тухай хуульд тусгах;
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлтөөс эхлээд гүйцэтгэж дуусах хүртэл бүхий л үе шатыг хамарсан цахим хувийн хэрэг нээж, олон нийтэд ил тод болгох замаар олон нийтийн хяналтад оруулах;
- Холбогдох хууль, журмыг зөрчсөн албан тушаалтанд зохих арга хэмжээг заавал авах, хүлээх хариуцлагыг чангаруулах.

Ном зүй

- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам
- Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотгол
- Монгол Улсын хөрөнгө оруулалтын 2021-2025 оны хөтөлбөр
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд анхаарах асуудал, Д.Оюунбадам, Нээлттэй Нийгэм Форум, 2020 он
- Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Гүйцэтгэлийн аудитын тайлан, Үндэсний аудитын газар, 2018 он
- Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Гүйцэтгэлийн аудитын тайлан, Үндэсний аудитын газар, 2020 он
- Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, Гүйцэтгэлийн аудитын тайлан, Үндэсний аудитын газар, 2022 он
- Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, Гүйцэтгэлийн аудитын тайлан, Нийслэл дэх Төрийн аудитын газар, 2022 он
- Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, Гүйцэтгэлийн аудитын тайлан, Үндэсний аудитын газар, 2023 он
- “Бүс нутгийн логиستيкийн төвийг хөгжүүлэх МОН2719/0240 төсөл”-ийн хэрэгжилтийн тайлан (2018 оны жилийн эцсийн байдлаар), Зам, тээврийн хөгжлийн яам
- <https://publicinvestment.gov.mn/>
- <https://legalinfo.mn>
- <https://mof.gov.mn/>
- <https://forum.mn>
- <https://tailan.audit.mn>
- <https://www.tender.gov.mn/mn/index/>
- <https://opendatalab.mn/>
- Effective public investment across levels of Government, Implementing the OECD principles, OECD, 2019

- Public Investment Management in the EU: Key features & Practices, Cristiana Belu Manescu, 2021 (https://economy-finance.ec.europa.eu/system/files/2022-10/dp154_en.pdf)
- https://track.unodc.org/uploads/documents/BRI-legal-resources/Kazakhstan/11_-_Budget_Code_EN.pdf
- <https://observatorioplanificacion.cepal.org/en/planning-systems/national-public-investment-system-chile>

Хавсралтууд

Хавсралт 1. Монгол Улсын 2017 оны батлагдсан төсөв дэх хугацаа нь өөрчлөгдөж шилжсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Хуулийн дугаар	Анх батлагдсан огноо	Төслийн нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Шилжихдээ хугацаа нь өөрчлөгдсөн эсэх
1	XVII.1.28	2014 он	Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлалын зураг төсөл, барилга угсралтын ажил	2015-2017	2014-2015 оны ажил байсан хэдий ч шилжихдээ 2015-2017 он болж өөрчлөгдсөн.
2	XI.1.46	2011 он	Нийслэл, аймгийн төвийн орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /улсын хэмжээнд/	2013-2018	2011-2014 оны ажил байсан хэдий ч шилжихдээ 2013-2018 он болж өөрчлөгдсөн.
3	XIII.1.1.43	2012 он	Увс аймгийн төвийн авто замын барилгын ажил / Увс, Улаангом сум/	2014-2017	2012-2014 оны ажил байсан хэдий ч 2014-2017 он болж өөрчлөгдсөн.
4	XIII.1.1.33	2012 он	Халзан бүргэдэй-Солонготын даваа чиглэлийн авто зам 100 км	2014-2017	2012-2014 оны ажил байсан хэдий ч 2014-2017 он болж өөрчлөгдсөн.
5	XII.1.1.2	2006 он	“Дэлхийн зөн” олон улсын байгууллагын тусламжийн Монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2010-2018	2006-2010 оны ажил 2010-2018 он болж өөрчлөгдсөн.
6	VII.1.1.1	2017 он	“Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт /улсын хэмжээнд/	2013-2018	Төсвийн хугацаа алдаатай. Өмнөх жилүүдийн улсын төсөвт тус арга хэмжээ тусгагдаагүй байсан бөгөөд 2017 оны төсөвт 2013-2018 он гэж тусгагдсан. ²⁰

20 “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн цахим хуудсанд мэдээлснээр Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 196 дугаар тогтоолоор хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, аймаг, томоохон суурин газрын дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулсан байна (<https://diir.mn/>).

7	XIII.1.1.51	2013 он	“Өндөрхаан-Мөнххаан-Баруун-Урт чиглэлийн 45.3 км хатуу хучилттай авто зам” ажлын дутуу санхүүжилт	2012-2018	Хугацаа 2013 оноос эхэлсэн байснаа 2012 он болж өөрчлөгдсөн.
8	XVII.1.17	2013 он	Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВа чадалтай компьютерын хяналт, удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил, 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2х2 км шилэн кабель бүхий аянгын тросстой цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил / УБ, ХУД/	2014-2017	2013-2014 он байснаа 2014-2017 он болж өөрчлөгдсөн.
9	XIII.1.1.44	2012 он	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын барилгын ажил 50 км	2013-2017	2012-2014 оны ажил 2013-2017 оных болж өөрчлөгдсөн.
10	XII.1.1.3	2006 он	Япон Улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн Монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2011-2017	2006-2011 оноос 2011-2017 он болж өөрчлөгдсөн.
11	XVII.1.24	2012 он	Сонгино 220/110/35 кВ-ын 2х125 МВа дэд станц, 220 кВ-ын 10 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Улаанбаатар/	2014-2017	2014 оны төсөвт хугацаа нь 2012-2014 он байхаар туссан.
12	XII.1.1.24	2012 он	Сургуулийн барилгын өргөтгөл /Говь-Алтай, Бугат сум/	2015-2017	2012-2016 оны ажил байсан.
13	IX.2.1.2	2014 он	Ахмадын ордны барилга /Завхан, Улиастай сум/	2015-2017	2014-2016 оноор туссан байсан.
14	XVI.1.17	2010 он	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Говь-Алтай, Цээл сум/	2010-2018	2011 оны төсөвт 2011-2012 он гэж туссан.
15	XI.1.16	2011 он	Шинээр барилгын материалын лаборатори байгуулах /Өмнөговь/	2013-2017	2011-2013 оны ажил байсан.
16	XII.4.1.10	2013 он	Спорт цогцолборын барилга /Дорноговь, Хатанбулаг сум/	2012-2017	2013 оны ажил байсан.
17	XII.1.1.54	2012 он	Бага сургууль болон дотуур байрын барилга /Өвөрхангай, Есөнзүйл сум/	2013-2017	2012 оны ажил байсан.

Эх сурвалж: Монгол Улсын 2011-2017 оны төсвийн тухай хууль, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)

Хавсралт 2. Монгол Улсын 2017 оны батлагдсан төсөвт шилжсэн, зарим жилүүдийн төсөвт тусгаагдаагүйгээс санхүүжилтгүй орхигдож байсан төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төслийн нэр	Эхлэх/ дуусах хугацаа	Төсвийн мэдээлэл дунд нь тасарсан байдал
1	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто зам 143 км	2013-2017	2013-2015 оны батлагдсан төсвөөс ижил хүчин чадалтай замын мэдээлэл олдоогүй.
2	Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлалын зураг төсөл, барилга угсралтын ажил	2015-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
3	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн авто зам, барилга 127.1 км	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
4	Нийслэл, аймгийн төвийн орон сууцын хорооллын инженерийн шугам сүлжээ /улсын хэмжээнд/	2013-2018	2011-2014 байсан хэдий ч шилжихдээ 2013-2018 болж өөрчлөгдсөн.
5	Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто зам 169.5 км	2013-2017	2013, 2014, 2015, 2016 оны батлагдсан төсвүүдээс ижил хүчин чадалтай төсөл, арга хэмжээ олдоогүй.
6	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Дээд боловсролын шинэчлэл” төслийн Монголын талын хөрөнгө / улсын хэмжээнд/	2012-2018	2012 оны батлагдсан төсвөөс мэдээлэл олдоогүй.
7	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа “Эрүүл мэндийн хөгжил” хөтөлбөр 4, 5 /улсын хэмжээнд/	2011-2020	2013 оны батлагдсан төсвөөс мэдээлэл олдоогүй.
8	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ш 800-ийн гол шугамыг Ш 1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөл, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, Павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/	2014-2020	2017 оноос өмнөх онуудын батлагдсан төсвөөс мэдээлэл олдоогүй.
9	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажлын үргэлжлэл / улсын хэмжээнд/	2014-2017	2015, 2016 оны төсвийн мэдээллээс олдоогүй.

10	Яармагийн гүүр орчмын орон сууцныхорооллын бохир ус, дулаан, цахилгааны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, ХУД/	2012-2018	2012 оны төслийн мэдээллээс олдоогүй.
11	Онцгой байдлын албаны командын байрын барилга /УБ, СБД/	2015-2017	2016 оны төсөвт тусгагдаагүй.
12	Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн авто замын барилга 60 км	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
13	Дулааны цахилгаан станц 4-өөс У-18 хүртэлх /Москва хорооллын урд тал хүртэл/ 4.2 км, Ш 800 -ийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил /УБ, БГД/	2014-2018	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
14	Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх /УБ, НД/	2012-2018	2012 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
15	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Улаанбаатар-Мандалговь чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн Монголын талын хөрөнгө / аймаг дундын/	2016-2019	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
16	Соёлын өвийн төвийн барилга /УБ, ХУД/	2012-2018	2012, 2013 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
17	Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний барилга /УБ, СБД/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
18	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургуулийн барилга, 960 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
19	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто зам 27 км	2013-2017	2015 оноос өмнөх онуудын мэдээлэл олдоогүй.
20	Гудамж төслийн хяналтын зөвлөх үйлчилгээ /Улаанбаатар/	2013-2017	2013, 2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
21	“Просолиуд” ХХК-иас Яармаг хүртэлх 3 км авто замын барилгын ажил /УБ, ХУД/	2014-2017	2014, 2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
22	Үндэсний номын сангийн барилга /УБ, СБД/	2012-2018	2012, 2013 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
23	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Замын- Үүдийн дэд бүтцийг сайжруулах” төслийн Монголын талын хөрөнгө /Дорноговь, Замын-Үүд сум/	2011-2017	Тус арга хэмжээ нь зураг төсөл боловсруулах, зөвлөх зэрэг өөр өөр дүн бүхий ялгаатай ажлуудаар өмнөх жилүүдийн төсөвт тусгагдсан.
24	Хилийн 0168 дугаар ангийн нүүлгэн шилжүүлэлт, инженерийн байгууламжийн дуусгалт /Дорноговь, Хатанбулаг сум/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.

25	ХБНГУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжих Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн Монголын талын хөрөнгө /Дархан-Уул, Дархан сум/	2015-2017	2015 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
26	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын дулааны 2 Ш 300/400 мм-ийн голчтой 1.1 км шугам, 1 ширхэг ус, дулаан дамжуулах төв, Ш 150 мм-ийн голчтой 137 метр шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эх үүсвэр, гадна төв бохир усны Ш 500 мм-ийн 1235 метр шугам, бохир усны Ш 200-300 мм-ийн 1788 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, СХД/	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй бөгөөд зураг төсөл бүрэн бус байсан.
27	Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2012-2018	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
28	“Ирээдүй” цогцолбор хорооллын дулааны 4100 метр гол шугам, 6 ширхэг дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
29	“Яармаг” орон сууцын хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд ойролцоо тооцоогоор 14.3 МВт чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, 2х400 кВА чадалтай ТП 36 иж бүрдэл, 37.6 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
30	Бельгийн вант улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах төсөл /Ховд, Жаргалант сум/	2013-2019	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
31	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Завхан, Улиастай сум/	2008-2017	2009 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
32	Мөрөн сумын дунд тойргийн 9.8 км хатуу хучилттай авто замын өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн сум/	2012-2017	2012, 2013, 2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
33	Сонгинохайрхан дүүрэг, Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг “Москва” хорооллын арын далангаар явуулж, “Өнөр” хорооллын 33 дугаар байрын арын замтай холбох 1 км авто замын зам барилгын ажил /УБ, СХД/	2014-2018	Өмнөх онуудын мэдээлэл олдоогүй.

34	“Өндөрхаан-Мөнххаан-Баруун-Урт чиглэлийн 45.3 км хатуу хучилттай авто зам” ажлын дутуу санхүүжилт	2012-2018	2012, 2013, 2014 оны төсвөөс уг мэдээлэл байхгүй.
35	Цэвэр, бохир усны шугам сүлжээ, усан сан, насосын станц, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт / УБ, Багахангай дүүрэг/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
36	Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын цахилгааны ХТП 9 ширхэг, 10 кв-ын кабель 5897 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, БЗД/	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
37	Спорт цогцолборын барилга /Завхан, Улиастай сум/	2012-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
38	Геронтологийн төвийн барилга, дэд бүтэц, 60 ор /УБ, ХУД/	2011-2019	2012, 2013, 2014, 2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
39	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2008-2017	2011, 2012 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
40	Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВа чадалтай компьютерын хяналт, удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил, 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2х2 км шилэн кабель бүхий аянгын тросстой цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, ХУД/	2014-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
41	“Алтанбулаг” чөлөөт бүсийн Сүхбаатар- Сэлэнгийн 25 км бохир усны шугам хоолойн ажил /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2012-2017	2013, 2014, 2015 оны төсвийн мэдээллээс олдоогүй бөгөөд 2016 онд тус хоолойн ажлыг дагасан цахилгааны ажлыг гүйцэтгэх арга хэмжээ гэж тусгагдсан.
42	Орон сууцын 14 дүгээр хорооллын цахилгааны 110/35/10 кВ-ын дэд станцын гаргалгаа 4 иж бүрдэл, 10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, 10 кВ-ын хаалттай дэд өртөө 12 иж бүрдэл, 10 кВ-ын 18.4 км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014-2018	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
43	“Буянт-Ухаа” хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд 9.9 МВт орчим чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын хуваарилах байгууламж 2 иж бүрдэл, 2х400 кВА чадалтай ТП 25 иж бүрдэл, 33 км урт 10 кВ-ын кабель шугам, зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, ХУД/	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.

44	Дулааны цахилгаан станц 3-ын баруун хойд замаас Яармагийн гүүр хүртэлх 1.5 км авто замын барилгын ажил	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
45	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын барилгын ажил 50 км	2013-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
46	Туул голын дагуу баригдах 35 км хурдны замын зураг төсөл боловсруулах /УБ/	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
47	Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /Дорнод, Хэрлэн сум/	2011-2018	2012, 2013, 2014 оны төсвөөс уг мэдээлэл байхгүй.
48	Ахуйн үйлчилгээний уулзварын зам барилгын ажил	2014-2017	2014, 2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
49	Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөл /УБ, БЗД/	2010-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
50	Хорооллын гадна шугам сүлжээний өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/	2014-2018	
51	"Алтай" чуулгын барилга, 500 суудал /Говь-Алтай/	2008-2017	2008-2012 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
52	Ажилчны гудамжнаас Дулааны цахилгаан станц 3 хүртэлх авто замын барилгын ажил /Улаанбаатар/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
53	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Дорнод, Хэрлэн сум/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
54	Багануур-Улаанбаатар-Дархан а 0401-Дархан чиглэлийн авто зам	2013-2018	2013, 2014 оны төсвөөс олдоогүй.
55	Сургуулийн барилга, 928 суудал /Хэнтий, Хэрлэн сум, 1 дүгээр сургууль/	2012-2017	2012, 2013, 2014 оны төсвөөс уг мэдээлэл олдоогүй.
56	Сургуулийн барилга, 640 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэ баг/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
57	Амгалан дулааны станц 348 МВт-ын туршилт, тохируулгын ажил /УБ, БЗД/	2015-2017	Өмнөх онуудын төсөвт станц барих ажлаар туссан бөгөөд уг арга хэмжээ өмнөх онуудаас олдоогүй.
58	Ботаникаас Шархад хүртэлх 2,36 км авто замын барилгын ажил /УБ, БЗД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
59	Аймгийн төвийн 3 дугаар тойргийн хатуу хучилттай авто замын засвар шинэчлэлийн ажил /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
60	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын тоног төхөөрөмж ажлын үлдэгдэл, Төрийн ордны тохижилт, их засварын ажил /УБ, СБД/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.

61	Орон сууцын 14 дүгээр хорооллын ус, дулаан дамжуулах төв 4 ширхэг, Ш 80/350 мм-ийн 1992 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил	2014-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
62	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр /Орхон, Баян-Өндөр сум/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
63	Баянголын амны орон сууцын хорооллын 10 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга, гадна дулаан, цэвэр ус, цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, БГД/	2013-2017	2013, 2014 оны төсвөөс олдоогүй.
64	Аврах гал унтраах ангийн барилга /Говь-Алтай аймаг, Есөн булаг сум/	2013-2017	2013, 2014 оны төсвөөс олдоогүй.
65	Сургуулийн хичээлийн байрын барилга /Дархан-Уул, Дархан сум, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургууль/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
66	Тэрхийн голын төмөр бетон гүүрийн зураг төсөл, их засвар 217.15 урт метр /Архангай, Тариат сум/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
67	Шивэрийн голын төмөр бетон гүүр /Увс, Ховд сум/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
68	Сургуулийн барилга /Сэлэнгэ, Сант сум/	2012-2017	2012 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
69	Баянголын амны 4 дүгээр ээлжийн дулааны ажил /УБ, БГД/	2013-2017	2013, 2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
70	Сургуулийн барилга, 320 суудал /Дундговь, Гурвансайхан сум/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
71	Сургуулийн хичээлийн байр, спорт заалын барилга, 320 суудал /Архангай, Хангай сум/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
72	Рашаантын газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн агуулах барих ажлын үлдэгдэл санхүүжилт /УБ, СХД/	2012-2018	Өмнөх онуудын төсөвт уг ажлыг концессийн гэрээгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
73	Сургуулийн барилгын өргөтгөл /УБ, БЗД, 33 дугаар сургууль/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
74	Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Эрдэнэ сум/	2012-2017	2012 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
75	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Биндэр сум/	2009-2017	2009 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
76	Сургуулийн барилга, спорт заал худалдаж авах, 160 суудал /Завхан, Баянхайрхан сум/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.

77	“Буянт-Ухаа” орон сууцын хорооллын 10 хэсгийн 10 ширхэг ЦТП, гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, ХУД/	2014-2017	2015 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
78	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто зам, хяналт 104 км	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
79	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн авто зам, хяналт 127.1 км	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
80	“Мандалговь-Даланзадгад чиглэлийн 83 км хатуу хучилттай авто зам” ажлын дутуу санхүүжилт	2013-2018	2013, 2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
81	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто зам, хяналт 95.4 км	2013-2017	2013, 2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
82	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/	2007-2017	Өмнөх оны төсвүүдээс мэдээлэл олдоогүй.
83	Баянголын амны Баянгол хорооллын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 2.2 км, дэд станц, 110/35/10 кВ, 2х40 МВа /УБ, БГД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
84	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт 4.5 км /Баян-Өлгий, Өлгий сум/	2016-2018	2017 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
85	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын 7 уулзварын өргөтгөн шинэчлэх болон замын засвар шинэчлэлийн ажил /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2015-2017	Өмнөх оны төсвүүдээс мэдээлэл олдоогүй бөгөөд 2017 оны төсөвт уг арга хэмжээний төсөв бүрэн тусгагдсан.
86	Шар хад, Амгалан орчмын бохир ус татан зайлуулах, ариутгах татуургын шугам сүлжээний ажил /УБ, БЗД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй бөгөөд 2015 оны төсөвт бүрэн санхүүжилтээр суусан.
87	220 кВ-ын “Сонгино” дэд станцаас 110 кВ-ын “Зайсан” дэд станц хүртэлх 110 кВ-ын 50 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
88	110/35/10 кВ-ын 2х40 МВа дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станцын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам хүртэлх 110 кВ-ын 2 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
89	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн авто зам, хяналт 67 км	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.

90	Сургуулийн барилга, 220 суудал / Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	2014-2017	2014 онд санхүүжилт нь бүрэн туссан.
91	“Гандантэгчэнлин” хийдийн өргөтгөлийн барилгын тохижилт, тоног төхөөрөмж, 1080 суудал /УБ, БГД/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
92	Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто зам, хяналт 83 км	2013-2017	2013, 2014 оны төсвөөс олдоогүй.
93	Хатуу хучилттай авто зам 1.79 км /УБ, БЗД, 11-р хороо, Хонхор тосгон/	2016-2017	2016 оны төсөвт бүрэн туссан бөгөөд уг нэмэлт санхүүжилтийн зориулалт тодорхой бус.
94	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Хөвсгөл, Цагааннуур сум/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй бөгөөд 2014 оны төсөвт бүрэн санхүүжилтээр туссан.
95	Аймгийн төвийн авто замын үлдэгдэл санхүүжилт 5.08 км /Орхон, Баян-Өндөр сум, Дэнж баг/	2013-2017	2013, 2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
96	Хан-Уул дүүргийн арын уулзварын барилгын ажил /УБ, ХУД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
97	Спорт заалын барилга /Булган, Хангал сум, Хялганат тосгон/	2012-2017	2015 оноос өмнөх төсвийн мэдээлэл олдоогүй.
98	Аймгийн төвөөс хилийн боомтууд чиглэлийн хатуу хучилттай авто замуудын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах /Дорнод, Хэрлэн сум, “Баянхошуу” боомт, Хавиргын боомт, “Ульхан” боомт/	2015-2017	2015 оны төсөвт бүрэн дүнгээр туссан.
99	VII хорооллын 12 хэсгийн 6 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга, гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй бөгөөд 2015 оны төсөвт бүрэн санхүүжилтээр суусан.
100	Соёлын төвийн барилга, 240 суудал / Хөвсгөл, Төмөрбулаг сум/	2012-2017	2012, 2013 оны төсвийн мэдээллээс олдоогүй бөгөөд 2014 онд бүрэн санхүүжилтээр төсөвт суусан.
101	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын 4 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажил /УБ, СХД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
102	Аймгийн төвийн авто замын дуусгалт 5.87 км /Орхон, Баян-Өндөр сум/	2013-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
103	Халзанбүргэдэй-Солонготын даваа чиглэлийн авто зам, хяналт 100 км	2014-2017	2015 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
104	100 айлын уулзварын барилгын ажил /УБ, СБД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.

105	“Гандантэгчэнлин” хийд орчмын гэр хорооллын инженерийн дэд бүтцийн ажлын зураг төсөл /УБ, БГД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
106	Усан хангамж Ш 500 мм-ийн 1800 метр, Ш 80/300 мм-ийн 3080 метр, ариутгах татуургын Ш 300 мм-ийн 1050 метр, Ш 400/200 мм-ийн 1310 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /Улаанбаатар/	2014-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
107	Ховд аймгийн төвийн 4200 м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил /Ховд, Жаргалант сум/	2013-2017	2013, 2014 оны төсвөөс олдоогүй.
108	Монгол-Солонгосын политехник коллежийн гадна шугам сүлжээний ажлын үлдэгдэл /УБ, ХУД/	2015-2017	2015 оны төсөвт бүрэн дүнгээр туссан бөгөөд уг нэмэлт санхүүжилтийн зарцуулалт тодорхой бус.
109	Сургуулийн барилгын өргөтгөл /УБ, БЗД, 48 дугаар сургууль/	2015-2017	2015 оны төсөвт бүрэн дүнгээр туссан бөгөөд уг нэмэлт санхүүжилтийн зарцуулалт тодорхой бус.
110	Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	2012-2018	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
111	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, /Хөвсгөл, Түнэл сум/	2015-2017	2015 оны төсвөөс мэдээлэл олдоогүй
112	“Буянт-Ухаа” орон сууцын хорооллын 20000 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийн гадна цахилгаан хангамжийн 2х1000 кВА чадалтай ХТП 2 иж бүрдэл, 7 км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, ХУД/	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй бөгөөд 2015 онд бүрэн санхүүжилтээр туссан хэдий ч 2017 онд дахин бүрэн санхүүжилтээр туссан.
113	“Баянгол” дэд станцаас 10 кВ-ын 3 иж бүрдэл хуваарилах байгууламж руу татах 12 км, 13.0 МВт чадлын хэрэглээг хангах кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, БГД/	2013-2017	2013, 2014 оны төсвөөс олдоогүй.
114	Дотуур байрын барилга, 120 ор /Төв, Батсүмбэр сум/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
115	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Өвөрхангай, Хужирт сум/	2015-2018	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
116	Өндрийн сүлжээний давтан хэмжилт, 1 дүгээр ангийн нивелирдлэг хийх /улсын хэмжээнд/	2013-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.

117	“Буянт-Ухаа” орон сууцны хорооллын 20000 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийн гадна дулаан хангамжийн өөрийн эх үүсвэртэй болгох зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, ХУД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
118	Авлигатай тэмцэх газрын В байрын барилгын их засвар /УБ, СБД/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
119	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Говь-Алтай, Цээл сум/	2010-2018	2010, 2014, 2015, 2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй
120	Хот суурин газрын ус хангамж, гидрогеологийн зураглалын судалгаа /Өвөрхангай, Гучин-Ус сум/	2015-2017	2015 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
121	Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголын дагуу бүсчлэл, инженер геологи, газар хөдлөлийн мужлалын нарийвчилсан зураг төсөл боловсруулах /Улаанбаатар/	2013-2017	2013 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
122	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум/	2010-2017	2010-2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
123	Улсын ерөнхий прокурорын газрын архивын барилга /УБ, ЧД/	2012-2017	2012-2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
124	Дулааны шугам сүлжээний Ш 32/200 мм-ийн голчтой 3539 метр шугамын барилга угсралтын ажил /Улаанбаатар/	2014-2018	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
125	220 кВ-ын Улаанбаатар дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станц хүртэлх 110 кВ-ын 9.7 км 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
126	Дулаан хангамжийн эх үүсвэр, хатуу түлшний халаалтын тогоо 5 ширхэг, ялтсан дулаан солилцуур 3 иж бүрдлийн барилга угсралтын ажил /Улаанбаатар/	2014-2018	Өмнөх оны төсвүүдээс мэдээлэл олдоогүй.
127	“Буман нарны гэрэл” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх ажлын үлдэгдэл санхүүжилт /улсын хэмжээнд/	2007-2017	Өмнөх онуудын төсөвт тусгагдаагүй бөгөөд 2017 онд бүрэн санхүүжилтээр туссан.
128	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын конторын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	2012-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
129	Усан хангамжийн Ш 32/150 мм-ийн 871 метр шугам, ариутгах татуургын Ш 300 мм-ийн 1246 метр шугамын угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.

130	Нийгмийн даатгалын тасгийн барилга /УБ, ЧД/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
131	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 14 ор /Баянхонгор, Баянцагаан сум/	2013-2018	2013, 2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
132	Цахилгааны хаалттай дэд өртөө 2х630 кВА 1 ширхэг, 2х800 кВА 3 ширхэг барилга угсралтын ажил / Улаанбаатар/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй бөгөөд 2015 оны төсөвт санхүүжилт нь бүрэн тусгагдсан.
133	110 кВ-ын “Баянгол” дэд станцаас 110 кВ-ын “Радио телевиз” дэд станц хүртэлх 110 кВ-ын 24 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил /УБ, БГД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
134	Орон сууцын 14 дүгээр хорооллын бохир усны Ш 200/350 мм-ийн 1897 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил, цэвэр усны Ш 200-350 мм-ийн 1166 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
135	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын цэвэр усны Ш 100/250 мм-ийн 1466 метр шугамын барилга угсралтын ажил /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2014-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
136	Дулааны Ш 65/200 мм-ийн голчтой 924 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
137	Ой ангийн конторын барилга / Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар/	2012-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
138	Баянгол дүүрэг, Гандан Орхоны 5 дугаар гудамжны дэд бүтцийн ажил / Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
139	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Цагаанхайрхан сум/	2015-2017	2016 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
140	Нэгдсэн эмнэлгийн угаалга, ариутгалын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2016-2017	2016 оны төсвийн мэдээллээс олдоогүй.
141	“Ирээдүй цогцолбор” хорооллын 2 дугаар ээлжийн 2х630 кВА чадалтай ТП 1 иж бүрдэл, 5 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.

142	“Ирээдүй цогцолбор” хорооллын 2 дугаар ээлжийн бохир усны Ш 150-450 мм-ийн голчтой 2200 метр гол шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
143	Баянгол дүүрэг, Гандан Орхоны 10 дугаар гудамжны шинэчлэлт, барилгын ажил /УБ, БГД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
144	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын бохир усны Ш 200-300 мм-ийн 995 метр шугамын барилга угсралтын ажил /УБ, СХД/	2014-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
145	Амгалан дулааны станцын ахуйн хэрэгцээний цэвэр усан хангамжийн угсралтын ажил /УБ, БЗД/	2014-2017	2014 оны төсвийн мэдээллээс олдоогүй бөгөөд 2015 онд бүрэн санхүүжилтээр туссан хэдий ч 2017 онд дахин бүрэн санхүүжилтээр туссан.
146	Цэвэр усны Ш 32/150 мм-ийн голчтой 1400 метр шугамын барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс олдоогүй бөгөөд 2015 онд бүрэн санхүүжилтээр туссан.
147	“Гандантэгчэнлин” хийд орчмын гэр хорооллын нөхцөлийг сайжруулах дэд төслийн хүрээнд Орхоны 10 дугаар гудамжны зам барилгын ажил /УБ, БЗД/	2014-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
148	Бохир усны Ш 150/200 мм-ийн голчтой 800 метр шугамын барилга угсралтын ажил	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
149	“Монел”, “Урбанек” худалдааны төвийн баруун урд, Хатанбаатар Магсаржавын гудамж, “Тоса” худалдааны төвийн арын, Нарны зам, 5 дугаар хороо, Загийн 24 дүгээр байрын зүүн урд уулзварын зураг төсөл	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
150	Халдвартын буудлаас Энхтайвны өргөн чөлөө хүртэлх авто замын зураг төсөл /УБ, БГД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.

151	Баянзүрх дүүрэг, Дандар баатрын гудамжнаас баруун тийш Офицеруудын ордны араар явуулж ШУТИС-ийн Холбоо мэдээллийн сургуулийн урд замтай холбох авто зам, Хилчний гудамжийг үргэлжлүүлэн Б.Доржийн гудамжтай холбох авто зам, 13 дугаар хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамжийг хороолол дундуур Нарны замтай холбох авто замын зураг төсөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
152	“Оргил” рашаан сувиллын уулзвараас “Жапан таун” хотхон хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл, Чингисийн өргөн чөлөө, Баянгол зочид буудлын зүүн уулзварын зураг төсөл /УБ, ХУД/	2014-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.
153	Нийгмийн даатгалын байгууллагуудын барилга, байгууламжийн зураг төсөл /улсын хэмжээнд/	2016-2017	2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
154	Улиастайн голын баруун талын 4 замын уулзварын зураг төсөл боловсруулах /УБ, БЗД/	2015-2017	2015, 2016 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
155	Хан-Уул дүүргийн арын уулзварын авто замын зураг төсөл /УБ, ХУД/	2014-2017	2014 оны төсвөөс мэдээлэл олдоогүй.
156	Сургуулийн барилга /Говь-Сүмбэр, Сүмбэр сум/	2014-2017	Өмнөх онуудын төсвөөс мэдээлэл олдоогүй.

Эх сурвалж: Монгол Улсын 2009-2017 оны төсвийн тухай хууль

Хавсралт 3. Монгол Улсын 2017 оны батлагдсан төсөв дэх зураг төслийн алдаатай төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төслийн нэр	ТЕЗ	Зөрчил
1	Гүүр 4 ширхэг /Сэлэнгэ мөрний төмөр бетон 422.5 урт метр гүүр, зураг төсөл, Сэлэнгэ мөрний дөрөө хангинахын хөвдөг гүүр, Дэлгэр мөрний хөвдөг гүүр, бирваазын шинэчлэл, Ерөө голын төмөр бетон гүүр/ /Булган, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн Баянзүрх, Их-Уул сум/	Зам, тээврийн хөгжлийн сайд	Төсөв батлагдсаны дараа зураг төсөл боловсруулах ажлын тендер зарлагдсан.

2	Ханх-Мондын чиглэлийн 23 км хатуу хучилттай авто зам /Хөвсгөл, Ханх сум/	Зам, тээврийн хөгжлийн сайд	Төсөв батлагдсаны дараа зураг төсөл боловсруулах ажлын тендер зарлагдсан.
3	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн харьяа Түлэнхийн төвийн барилга /УБ, СБД/	Эрүүл мэндийн сайд	
4	Нийслэлд ажиллаж байгаа 68 ширхэг халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчдийг дулааны төвлөрсөн системд холбох	Эрчим хүчний сайд	
5	Говийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	Эрүүл мэндийн сайд	
6	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Дорнод, Хэрлэн сум/	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	
7	Эрүүл мэндийн салбарын их засвар /улсын хэмжээнд	Эрүүл мэндийн сайд	Баталгаажсан зураг төсөл байхгүй.
8	Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ /Засгийн газрын 2015 оны 313 дугаар тогтоолын хүрээнд хийгдэх авто зам/ /Төв, Сэргэлэн сум/	Зам, тээврийн хөгжлийн сайд	
9	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	Эрүүл мэндийн сайд	Хийлгэсэн зураг төсөлд магадлал хийлгүүлээгүй, гэрээний өртгөөс илүү өртөг тусгасан.
10	Соёлын өвийн төвийн барилга /УБ, ХУД/	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	Инженерийн шугам сүлжээний зураг төсөлд магадлал хийлгүүлээгүй, дараа нь магадлал хийгдэж төсөвт өртөг нь нэмэгдсэн.
11	Сургуулийн барилга, 640 суудал / Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 104 дүгээр сургууль/	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	Нэмэлт ажлын төсвийг магадлалаар баталгаажуулаагүйн дээр техникийн нөхцөлүүд олгогдоогүйгээс 2014 оноос хойш сунжирсан.
12	Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний барилга / Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Нэмэлт ажлын төсвийг магадлалаар баталгаажуулаагүй.

13	Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний шинэчлэл / Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	Гадаад харилцааны сайд	
14	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургуулийн барилга, 960 суудал / Дорноговь, Замын-Үүд сум/	Барилга, хот байгуулалтын сайд	Хийлгэсэн зураг төсөлд магадлал хийлгүүлээгүй.
15	Төрөх эмнэлэг, 50 ор / Дорноговь, Сайншанд сум/	Эрүүл мэндийн сайд	
16	Сургуулийн барилга, 240 суудал / Булган, Гурванбулаг сум/	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	
